

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2025 ОНЫ 06 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
2025 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ
ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 – 4
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	5 – 59

1.	<i>Улаанбаатар хотын автотээврийн хэрэгслийн албан татварын нэмэгдлийг цуцлах талаар гаргасан нийтийн өргөдлийг судлан үзэж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт</i>	6 – 53
2.	<i>Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх тухай асуудал</i>	53 – 57
3.	<i>Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/</i>	58 – 59

**Монгол Улсын Их Хурлын 2025 оны хаврын ээлжит чуулганы
Төсвийн байнгын хорооны 06 дугаар сарын 10-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 28 минутад Төрийн ордны “Их засаг” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ж.Батжаргал, Д.Батлут, Б.Батцэцэг, Ж.Ганбаатар, П.Мөнхтулга, Г.Тэмүүлэн.

Нэг.Улаанбаатар хотын автотээврийн хэрэгслийн албан татварын нэмэгдлийг цуцлах талаар гаргасан нийтийн өргөдлийг судлан үзэж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлт

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга М.Баяраа нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Байнгын хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор байгуулагдсан Улаанбаатар хотын автотээврийн хэрэгслийн албан татварын нэмэгдлийг цуцлах талаар гаргасан нийтийн өргөдлийг судлан үзэж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир танилцуулав.

Ажлын хэсгийн танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Б.Түвшин, П.Сайнзориг, Ж.Баясгалан, Д.Пүрэвдаваа, Д.Батбаяр, Г.Ганбаатар, Б.Чойжилсүрэн нарын тавьсан асуултад ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Х.Ганхуяг, Б.Түвшин, Х.Болормаа, Ж.Баясгалан, Да.Цогтбаатар, Н.Алтанхуяг, Г.Ганбаатар, Г.Дамдинням, Ц.Даваасүрэн нар үг хэлэв.

Ажлын хэсгээс гаргасан “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийн хэлэлцэх асуудлыг хойшлуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 25 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх тухай асуудал

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяа Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх тухай асуудлыг хойшлуулах гэсэн горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Х.Булгантуяагийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 4
Татгалзсан: 15
Бүгд: 19
21.1 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигчдийг танилцуулав.

Ц.Даваасүрэн: Ө.Гэрэлт-Одыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 8
Бүгд: 19
57.9 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн З.Мэндсайханы “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 63.2 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Уг асуудлыг 12 цаг 38 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Байнгын хорооны тогтоолын төсөл /Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Байнгын хороодын ажлын албаны Аж үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Б.Батдэлгэр, референт Г.Нямсүрэн нар байлцав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт асууж, үг хэлээгүй болно.

Ц.Даваасүрэн: “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох тухай, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11

Татгалзсан: 8

Бүгд: 19

57.9 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 12 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 12 минут үргэлжилж, 25 гишүүнээс 19 гишүүн хүрэлцэн ирж, 76.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 40 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

ТӨСВИЙН БАЙНГЫН

ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААН ЗОХИОН

БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН

ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 06 дугаар сарын 10-ны өдөр, Мягмар гараг
Төрийн ордны “Их засаг” танхим
10 цаг 28 минут

ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Гишүүдийнхээ энэ өдрийн амгаланг эрье.

Төсвийн байнгын хорооны хуралд ирэх 25 гишүүнээс 13 ирсэн байна. Ирц 52 хувьтай байгаа учраас Байнгын хорооны 2025 оны 06 сарын 10-ны өдрийн хуралдааныг нээснийг мэдэгдье.

Би ирсэн гишүүдээ танилцуулъя.

Норовын Алтанхуяг, Ринчиндоржийн Батболд, Гомбын Ганбаатар, Цэрэнпилийн Даваасүрэн, Банзрагчийн Түвшин, Тилеуханы Аубакир, Жадамбаагийн Баясгалан, Пүрэвжавын Ганзориг, Баатаржавын Мөнхсоёл, Загджавын Мэндсайхан, Банзрагчийн Түвшин, Далайн Батбаяр, Хөххүүгийн Болормаа, Хассуурийн Ганхуяг, Даваагийн Цогтбаатар гэсэн гишүүд ирсэн байна.

Байнгын хорооноор хэлэлцэх асуудлыг Та бүхэнд танилцуулъя.

Гурван асуудал хэлэлцэхээр төлөвлөлөө.

Эхний асуудал. Байнгын хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор байгуулагдсан Улаанбаатар хотын авто тээврийн хэрэгслийн албан татварын нэмэгдлийг цуцлах талаар гаргасан нийтийн өргөдлийг судлан үзэж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсгийн санал, дүгнэлттэй танилцана.

Хоёр. Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүний нэр дэвшүүлэх асуудал.

Гурав. “Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагч сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төсөл гэсэн гурван асуудал байна.

Хэлэлцэх асуудалтай холбогдолтой саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ингээд хэлэлцэх асуудалдаа оръё.

Байнгын хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор байгуулагдсан ажлын хэсгийн санал дүгнэлтийг хэлэлцэж эхэлье.

**Нэг.Улаанбаатар хотын автотээврийн хэрэгслийн
албан татварын нэмэгдлийг цуцлах талаар гаргасан
нийтийн өргөдлийг судлан үзэж, санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий
ажлын хэсгийн санал, дүгнэлт**

Т.Аубакир гишүүн Та танилцуулна.

Т.Аубакир: Манайхад материал тараагаад өгсөн байгаа юу? Тийм ээ. Санал, дүгнэлтүүдээ.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д Улсын Их Хурлын хууль тогтоох, хянан шалгах үйл ажиллагаанд иргэдийн оролцоог хангах зорилгоор нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар иргэдээс гаргасан өргөдлийг цахим системээр хүлээн авч болно гэж. Мөн зүйлийн 39.2-т нийтийн өргөдлийг Монгол Улсын Үндсэн хуулийн 25 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1 болон 8-д заасан Улсын Их Хурлын бүрэн эрхэд хамаарах асуудлын хүрээнд гаргана гэж заасан.

Энэ хүрээнд 2025 оны 03 дугаар сарын 17-ны өдөр иргэн Энхтөрийн Батбаяр Улаанбаатар хотын тээврийн хэрэгслийн татварын нэмэгдлийг цуцлах асуудлаар гаргасан өргөдлийг 33 мянга ба түүнээс дээш тооны иргэд дэмжсэн тул Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2025 оны 04 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаараа хэлэлцэж, Байнгын хорооны 2025 оны 06 дугаар тогтоолоор ажлын хэсгийг байгуулсан бөгөөд ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, ажлын хэсгийн гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Ж.Баясгалан, Б.Заяабал, Б.Мөнхсоёл, Д.Пүрэвдаваа нар ажиллалаа.

Ажлын хэсэг 2025 оны 04 дүгээр сарын 14, 06 дугаар сар сарын 04-ний өдрүүдэд хуралдаж, Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Их Хурлын тухай хууль, Монгол Улсын хяналт шалгалтын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай, Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль болон Захиргааны ерөнхий хууль зэрэг нийслэл Улаанбаатар хотын авто тээврийн татвартай холбогдох хууль тогтоомж болон холбогдох шийдвэрт дүн шинжилгээ хийж, эрх бүхий албан тушаалтны мэдээллийг сонсож, бусад баримт бичигтэй танилцлаа.

Хууль эрх зүйн зохицуулалтын талаар.

Монгол Улсын Үндсэн хуулийн 17 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад Монгол Улсын иргэн хуулиар ногдуулсан албан татвар төлөх үүрэгтэй гэж заасан бөгөөд энэ нь нэг талаар Монгол Улсын төрийн тогтолцоо, иргэдийн үүргийг тодорхойлсон заавал биелэгдэх шинжтэй хэм хэмжээ, нөгөө талаар Монгол Улсын иргэн хуулиар ногдуулаагүй татвар, төлбөр, хураамж төлөхгүй байх эрхийн нэг чухал баталгаа юм.

Монгол Улсын Үндсэн хууль ёсоор хууль, түүний дотор авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдуулах албан татварыг хуульд заасан хэмжээ, хязгаарт багтаан зохион байгуулж хангах үүргийг аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хуулиар олгосон байна.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулиар нийслэл нь хараат бус бие даасан статустай байх, бие даасан төсөвтэй байх, хууль тогтоомжид заасан хүрээнд албан татвар, төлбөр хураамжийн хувь хувь хэмжээг тогтоох зэрэг асуудлыг хуульчилсан байх бөгөөд энэ нь иргэн эрүүл, аюулгүй, амар тайван орчинд ажиллах, амьдрах бололцоог хангах, төвлөрлийг сааруулах, иргэний эдлэх эрх үүрэг, хариуцлага хүлээх чадварыг бүрдүүлэх зорилго бүхий зохицуулалт юм.

Харин Монгол Улсын Их Хурал нь ард түмний төлөөллийн дээд байгууллагын хувьд хууль батлах, төрийн дотоод, гадаад бодлогын үндсийг тодорхойлж, хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах үндсэн чиг үүргийг гүйцэтгэдэг бөгөөд хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэхдээ ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх, түүнчлэн бие даасан, нээлттэй, ил тод байх, цөөнхийн саналыг хүндэтгэн асуудлыг олон талт үзэл бодлын үүднээс чөлөөтэй хэлэлцэж, олонхын саналаар асуудлыг шийдвэрлэх зарчимд үндэслэдэг билээ.

Иргэн Энхтөрийн Батбаярын гаргасан өргөдөлтэй холбогдох хуулийн зохицуулалтын талаар.

1992 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хууль нь хувь хүн аж ахуйн нэгж, байгууллагын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд албан татвар ногдуулах. Уг албан татварыг төсөвт төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулж байгаа бөгөөд уг хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгээр авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн жилийн албан татварыг ногдуулах асуудлыг хуульчилжээ.

Тухайлбал, иргэн Э.Батбаярын гаргасан Нийслэл Улаанбаатар хотын авто тээврийн жилд ногдуулах албан татварын дээд, доод хязгаарыг хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтад дараах байдлаар тогтоосон байна гээд ийм хүснэгт байгаа. Манай гишүүд харж байгаа байх.

Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан авто тээврийн болон өөрөө явагч хэрэгсэлд ногдуулах албан татварын хэмжээг Улсын Их Хурлаас баталсан хязгаарт багтаан албан татвар төлөгчийн авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн бүртгэлтэй аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал улсын зэрэглэлтэй хотын зөвлөл тогтооно гэж заасны дагуу Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2010 оноос хойш суудлын автомашины албан татварын хэмжээнд өөрчлөлт оруулаагүй байна.

Нийслэлийн авто замын сүлжээг өргөтгөх шинэчлэх зорилгоор Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдрийн 07 дугаар тогтоолоор нийслэл Улаанбаатар хотын авто тээврийн албан татварын хувь хэмжээг хуульд заасан хязгаарт багтаан 4 төрлийн авто тээврийн хэрэгслийн жилд төлөх татварын хэмжээг 2010 оныхоос 3 дахин нэмэгдүүлжээ.

Дээрх хууль, эрх зүйн зохицуулалтаас дүгнэн дараах санал, дүгнэлтийг Байнгын хороонд танилцуулж байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлээр хуулийн биелэлтийг зохион байгуулж хангах талаар Засгийн газрын бүрэн эрхийг заасан байх бөгөөд мөн зүйлийн 1-д төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагаас хуулийн биелэлтийг зохион байгуулж, хангах арга замыг тодорхойлсон уг ажлыг нэгтгэн удирдана гэж, 3-д төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын шийдвэр хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд хяналт тавина гэж. Мөн Захиргааны хуулийн 48 дугаар зүйлийн 48.2.2 дахь заалтад бусад этгээдийн эрх хууль, ёсны ашиг сонирхол, эсхүл нийтийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлсөн гэж үзвэл захиргааны байгууллага тухайн захиргааны актыг бүхэлд нь, эсвэл хэсэгчлэн хүчингүй болгоно гэж заасны дагуу ажлын хэсгээс Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас татвар нэмэгдүүлэх хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахдаа тооцоо судалгаа дутуу, олон нийтийн санал асуулга авах асуудлын процесс алдаа гарсан байх магадлалтай тул нутгийн өөрөө удирдах байгууллага гаргасан шийдвэрээ эргэн харж, засаж сайжруулах, цаашид гадагшаа чиглэсэн хэм хэмжээ тогтоосон шийдвэр гаргахдаа иргэд, олон нийт, бүх талуудын оролцоог хангасан хэлэлцүүлгийг өргөн хүрээнд явуулж, гарсан үр дүнд тулгуурлан шийдвэр гаргах нь зүйтэй гэж Улсын Их Хурлын гишүүн Д.Пүрэвдаваа, Ж.Баясгалан нар ийм санал хэлсэн.

Монгол Улсын Их Хурлын тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд заасан журмыг үндэслэн Төсвийн байнгын хорооны “Монгол Улсын Засгийн газарт чиглэл өгөх тухай” тогтоолыг Засгийн газарт хүргүүлэх саналыг гаргаж байна.

Энэ хүрээнд ажлын хэсгээс тогтоолын төслийг боловсруулан Та бүхэнд тараасан байгаа.

Тогтоолын төсөлд хуулийн хэрэгжилт, биелэлтийг хангах үйл ажиллагаанд олон нийтийн оролцоог хангах, нийтийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хөндсөн аливаа асуудалд өргөн хүрээний хэлэлцүүлэг зохион байгуулах, хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч байгаа саад бэрхшээл, зөрчил, практикт гарч байгаа асуудлын шалтгаан нөхцөлийг эрт илрүүлж эерэг эдгээртэй уялдуулан шийдвэр гаргах зэрэг асуудлыг тусгасан болно.

Ингээд Засгийн газар луу чиглэл өгсөн тогтоолын төсөл бэлдсэн байгаа.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Нийтийн өргөдлийг судлан үзэж санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал, дүгнэлт болон Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг Та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Даваасүрэн: Т.Аубакир гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгээс гадна Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч Т.Даваадалай, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Амгалан, Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат, Нийслэлийн Замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга М.Баяраа гэсэн хүмүүс нийслэлээс оролцож байна.

Т.Аубакир гишүүний хийсэн танилцуулга, тогтоолын төсөлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүдийн нэрсийг авъя.

Х.Ганхуяг гишүүнээр тасалъя. Х.Ганхуяг гишүүн асуултаа асууя.

Х.Ганхуяг: Бид 2024 онд Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг батлахдаа энэ авто тээврийн хэрэгсэлтэй холбоотой дээд, доод хязгаарыг нь тогтоож өгсөн байдаг.

Татвар ногдуулах эрхийг нь тухайн орон нутгийн...

За байгаарай, манайхан.

Тухайн орон нутагт нь эрх мэдлийг нь тогтоох эрхийг нь өгсөн байдаг. Тэгээд яах вэ, бид чинь үндсэндээ 2012 оноос хойш авто тээврийн хэрэгсэлтэй холбоотой татварыг ерөөсөө шинэчилж чадаж байгаагүй. Гэтэл жил болгон зам

тавих шаардлага үүсдэг. Тэгээд одоо үндсэндээ яаж байна гэхээр тэр татварыг оролдохгүй байхаар нэг ёсондоо автобусаар зорчиж байгаа хүнээс татварыг нь аваад тэгээд энд автомашин тэрэгний замыг нь тавьж өгдөг ийм нөхцөл байдал үүсээд байгаа.

Тэгэхээр нэг талаараа харвал нөгөө хэрэглээн дээр суурилсан татваруудын нэг байхгүй юу. Энэ үндсэндээ. Нэг ёсондоо тухайн авто тээврийг хэрэглэж байгаа хүмүүсээс татварыг нь аваад замыг нь засдаг, тавьдаг энэ юу руугаа л явж байна гэсэн үг.

Тэгэхээр би ажлын хэсэг сайн ажилласан байна л гэж харж байна. Ингэж явахаас өөр аргагүй.

Бид аль болох хэрэглээн дээр суурилсан татварыг нэмэгдүүлж байж яг тэр зориулалтаар нь ашигладаг байх нь өөрөө төсвийн бодлогын юутайгаа уялдаж явах ёстой юм гэж харж байгаа юм. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Санал хэллээ. Тийм ээ. Тогтоол байгаа учраас тогтоолтой холбогдуулж асуугаарай Та бүхэн.

Б.Түвшин гишүүн асуултаа асууя.

Б.Түвшин: Нэгдүгээрт, Нийслэлийн иргэдийн Хурал энэ шийдвэрийг гаргахдаа иргэдээс санал хүсэлт, иргэдийн оролцоо, хэлэлцүүлгүүдийг дутуу хийсэн гэж дүгнээд тэрийгээ дахиж гүйцээе гэж орж ирж байна гэж ойлгож байгаа. Энэ зөв үү? Нэгдүгээр асуулт

Хоёрдугаарт, яг энд хэдэн иргэн, хэдэн тээврийн хэрэгсэл хамрагдаад, хэр хэмжээний мөнгө цугласан, тэр нь нэмэгдэл цугласан мөнгөөр юу хийсэн, үр ашигтай зарцуулсан эсэх.

Гуравдугаарт, ер нь цаашдаа татварыг нэмээд, татвар нэмсэн мөнгөө үр ашигтай, тэр авснаасаа илүү эдийн засгийн өгөөжтэйгөөр зарцуулж чадаж байгаа эсэх дээр дүгнэлт гаргасан уу? Энэ талаар тодорхой тайлбар хийнэ үү гэсэн ийм гурван асуулт байна.

Ц.Даваасүрэн: Хэн хариулах юм? Т.Аубакир гишүүн.

Т.Аубакир: Ер нь ажлын хэсгийн гишүүдийн ярьсан өнцөг гэх юм уу даа. Иргэдээсээ нээлттэй тийм санал авах ёстой гэсэн байр суурьтай байгаа. Манай Ж.Баясгалан гишүүн, Д.Пүрэвдаваа гишүүн маань.

Үүнийг эхний хурал дээр бид нийслэлийн удирдлагуудаас асуусан. Санал асуулгаа хуулийн хүрээнд явуулсан гэдгээ хэлсэн.

Тийм учраас тогтоол дээр сайд та тогтоолоо анхааралтай харсан бол ер нь иргэдээс энэ санал авах процесс чинь яг хуулийн дагуу явсан юм уу даа гэдэг л асуудал бид яриад. Ажлын хэсгийн ерөөсөө ганцхан тавьж байгаа зүйл бол Д.Пүрэвдаваа гишүүн, Ж.Баясгалан гишүүн иргэдээс энэ санал авах процесс чинь яг зөв явсан юм уу гэдэг л асуулт тавьж байгаа.

Түүнээс биш татвар нэмэх нь зөв, эсвэл буруу гэсэн асуудал энд огт яригдаагүй.

Яагаад гэхээр Улсын Их Хурлаас татварын дээд, доод интервалыг тогтоогоод өгсөн. Энэ интервал дотроо л нутгийн өөрөө удирдах байгууллага нь шийдвэр гаргасан байхгүй юу.

Тийм учраас бидний гол тавьж байгаа асуудал яг энэ процессоо. Манай нийслэлийн удирдлагууд тайлбарлаарай.

Яг энэ иргэдийн Хурал дээр татварын асуудлыг хэлэлцэх үед яг дэгийнхээ дагуу иргэдээс санал асуулгаа явсан юм уу, бусад тооцооллуудаа зөв хийсэн юм уу гэдэг.

Тэгээд хоёрдугаар асуулт дээр хэн хариулах юм. Нийслэлээс Замын дарга.

Энэ авсан татвараа яг зөв зарцуулж байгаа юм уу, юунд зарцуулж байгаа юм бэ гэдэг талаараа тайлбар тавиач гэж байна шүү дээ.

Ц.Даваасүрэн: Хэддүгээр микрофон. 5 дугаар микрофон гишүүний асуултад хариулъя.

Т.Даваадалай: Эрхэм гишүүдийн энэ өдрийн мэндийг хүргэе. Нэгдүгээр асуулт дээр.

Ц.Даваасүрэн: Албан тушаалаа хэлээд. Протокол явж байгаа учраас нэрээ хэлнэ.

Т.Даваадалай: Нийслэлийн Засаг даргын Эдийн засгийн хөгжил, дэд бүтэц хариуцсан нэгдүгээр орлогч дарга Т.Даваадалай. Гишүүний асуултад хариулъя.

Нэгдүгээр асуулт дээр бид процессын дагуу хоёр үе шаттай, 2 удаа иргэдээс санал асуулга асуусан.

Нэгдүгээрт нь, зөвхөн авто замын татвартай холбогдолтой санал асуулгыг журамд заасны дагуу 2024 оны 10 дугаар сарын 18-нд www.ulaanbaatar.mn-ээр зарлалыг байрлуулж, иргэдийн саналыг авсан.

Дараа нь, 2025 оны төсөвтэй уялдуулаад бас.

Ц.Даваасүрэн: Хэдэн санал ирсэн.

Т.Даваадалай: 2 санал ирсэн байгаа.

Дараа нь, 2024 оны 04 сарын 15-наас 2025 оны 06 дугаар сарын 15-ны хооронд 2 сарын хугацаанд... /минут дуусав/

Ц.Даваасүрэн: 5 номерын микрофоныг дахиад сунгая.

Т.Даваадалай: Мөн 2025 оны төсөв батлахтай холбогдуулаад 2024 оны 04 сарын 15-наас 06 сарын 15-ны хугацаанд 2 сарын хугацаанд иргэдээс татвар нэмэгдэж байгаа болон 2025 оны төсөвтэй холбогдолтой санал асуулга авахад зүгээр нийт тоогоороо 147 мянга 342 хүний санал асуулга ирсэн.

Мөн 2025 оны 11 дүгээр сард 400 гаруй иргэдтэй уулзалтыг уулзалтыг зохион байгуулж, 2025 оны нийслэлийн төсвийг хэлэлцсэн байгаа.

Хоёрдугаар асуулт дээр хариулахад, нийт энэ жил нийслэлийн авто замын сангийн орлогоор ойролцоогоор 220 тэрбум төгрөг төвлөрөхөөр байгаа. Үүнээс нийт 97 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлнэ. 104 авто замын байрлалыг шинэчлэхээр байгаа. 30 километрийн шинэ байрлал 53 байрлал дээр, 74 километрийг 44 байрлал дээр засварлах ажиллагааг төлөвлөж хийхээр төлөвлөж байгаа.

Өнөөдрийн байдлаар 134 тэрбум орсон байгаа.

Ц.Даваасүрэн: 3. Албан тушаал, нэрээ хэлээд.

Б.Одбаяр: Сайн байцгаана уу? Нийслэлийн замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр гишүүний асуултад хариулъя.

Хэр үр ашигтай зарцуулж байна вэ гээд.

Тэгэхээр би Калифорни мужид CALTRANS /California Department of Transportation/ буюу яг энэ авто замын хөрөнгийн менежментийн системээр засвар шинэчлэлийн ажлуудыг 3 жил хариуцаж ажиллаж байсан.

Тэгэхээр эхлээд бүх замууд дээрээ судалгаа хийж байгаа юм. Тэгээд бид 2022 онд лазер хэмжигч багажаар Зам тээврийн хөгжлийн төвөөс түрээслээд замууд дээрээ судалгаа хийсэн.

Замууд дээрээ судалгаа хийгээд үзэхэд нийт авто замын 82.2 хувь нь өөрөө ашиглалтын шаардлага хангахгүй байна гэдэг тэгш байдлын үзүүлэлтүүдээр нь гаргаж ирж байгаа юм.

Тэгээд тэгш байдлын үзүүлэлтүүдээр нь гаргаж ирэхэд 82.2 хувь нь хангахгүй байна. Тэгээд тухайн төсөвт өртгөөрөө замынхаа хэмжээсээр нь аваад үзэхэд 1231 километр авто замын байдлаар... /минут дуусав/

Ц.Даваасүрэн: 3 номерын микрофоныг сунгая.

Б.Одбаяр: 10 жилийн дараа гэхэд манай нийт авто замын бараг 95 хувь нь чанарын шаардлага хангахгүй болно гэж байгаа юм.

Тэгэхээр бид нийт засвар арчлалтын төсөвт өртгөө хараад.

▶ Анх 2013 онд зам ашигласны төлбөр батлагдахад нийт авто замын урт 400-хан километр байсан.

▪ Одоо 1231 километр авто замтай болсон.

▶ Төсөвт өртөг нь 1 метр квадрат нөхөөс хийхэд 55 мянга байсан.

▪ Одоо 110 мянган төгрөг болсон.

Ингээд үнэ бодсон ч тэр, замынхаа уртыг бодсон ч тэр ихсээд байдаг. Авч байгаа, хурааж байгаа мөнгө нь 20 тэрбум төгрөг хэвээрээ байгаад байх юм бол бид нийт авто замынхаа 1.5 хувийг л засаж байгаа. Жил болгон яг энэ мөнгөөрөө.

Ингэх юм бид 10 жилийн дараа гэхэд дахиад л яг л ийм доошоо суусан, шигдсэн замтай яг энэ чигээрээ үлдэнэ гэсэн үг.

Тэгэхээр хөрөнгийн менежментийн систем хэрэгжихийн тулд тогтвортой хэдэн төгрөг замын сандаа орох юм бэ гэдэг нь маш чухал байдаг учраас яг энэ хөрөнгийн менежментийн системийг хэрэгжүүлэхийн тулд яг нэг тогтсон дүнгээрээ явах... /минут дуусав/

Ц.Даваасүрэн: Тодруулъя. Б.Түвшин гишүүн.

Б.Түвшин: Яах вэ, нэг талаасаа авто тээврийн болон элдэв татваруудыг нэмээд, менежментээ хийе гэж байгаа бол байх энгийн логик.

Нөгөө талаасаа инфляц өсөөд, иргэдийн ахуй орлого нь багасаж байгаа үед энэ татварыг огцом 3 дахин нэмж, тэгээд дээрээс нь иргэдийн бухимдлыг төрүүлээд, хэлэлцүүлгүүдийг иргэдэд дутуу байдалтайгаар хийгээд ийм шийдвэр гаргаж байгаа нь бас энэ Улаанбаатарчуудын хувьд маш том стресстэй зүйл болж байна гэж би хувьдаа дүгнэж байна.

Саяын таны хэлдэг шиг яг энэ авсан татваруудын зарцуулалтын талаар, бүтээмж, үр ашгийн талаар тодорхой зүйлийг хэлсэнгүй гэж би хувьдаа ойлгож байна.

Тийм учраас ажлын хэсгийн гаргаж байгаа дүгнэлтийн дагуу хэлэлцүүлгүүд бүрэн эсэх дээр, иргэдийн 100 хэдэн мянган саналаа өгсөн иргэдийн асуудлыг хүндэтгэж үзэж чиглэл буцааж өгөх нь зүйтэй гэж үзэж байна.

Ц.Даваасүрэн: Санал хэлэв үү? П.Сайнзориг гишүүн асуултаа асууя.

П.Сайнзориг: Баярлалаа. Би яах вэ. Ер нь асуултууд давхцаж байна. Тэгэхдээ хоёр зүйлийг тодруулж хэлээч ээ гэж хүсэж байгаа юм.

Ерөнхийдөө авто замын асуудал маань өөрөө хөрөнгийн менежменттэй асуудал байгаа.

Улс, нийслэлийн болоод бондын хөрөнгөөр хийсэн байгаа замын арчлалт, хамгаалалтыг цаг тухайд нь хийж явахгүй бол бүр нөхөөс авахгүй хэмжээнд очсоны дараа буюу суурь бүтээц нь эвдэрсний дараа замыг дахиж бүр эхнээс нь шинэчлэх ажлыг маш өндөр өртөгтэйгөөр хийдгээс болоод замын арчлалт, хамгаалалт ерөөсөө дуусдаг.

Сая Х.Ганхуяг гишүүн хэлж байна. Хэрэглэгч нь төлөх тэр зарчим руу оруулж байгаа нь зөв өө л гэж би хэлэх гэж байгаа юм. Өөрөөр хэлэх юм бол авто зам ашиглаж байгаа буюу тээврийн хэрэгсэл өмчилж байгаа, үүнийг ашиглаж байгаа хүмүүс нь авто зам ашигласан төлбөрөө төлөөд явахгүй бол авто зам ашигладаггүй автобусаар зорчдог иргэд, татвар төлөгчдийн мөнгөнөөс буюу нийслэлийн төсвөөс, улсын төсвөөс замын ачилт хамгаалалтыг хийх ийм нөхцөл байдал руу бид цаашдаа оруулж болохгүй.

Тийм учраас 2010, 2011 оноос хойш өөрчлөгдөөгүй байгаа татварыг яг энэ хуулийнхаа интервал дотор нэмж байгаа нь зөв байх л гэж би хувьдаа бодож байгаа юм.

Мэдээж гишүүдийн хэлж байгаа олон нийтээр хэлэлцүүлэх энэ процесс энэ тэрээ хянах нь зөв.

Яах вэ, магадгүй Улсын Их Хурал энэ процессыг хянаж шийдвэрийг гаргасан уу, үгүй юу гэдгийг ярих зохимж нь хэр байдаг юм бол. Захиргааны хэргийн шүүх бол магадгүй процессын алдаа гарсан бол актыг түдгэлзүүлээд хүчингүй болгох эрх нь тэнд байгаа байхгүй юу.

Тэгэхээр бид хэд сүүлдээ нөгөө хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагаанд хүртэл ингээд хутгалдаад байгаа юм биш биз дээ. Энэ иргэдийн хурлын шийдвэртэй холбоотой захиргааны хэрэг ч байдаг юм уу, шүүхүүд дээр

үүссэн маргаанууд бий юу? Тэнд маргаан явж байхад бид хэд энд хэлэлцэх, тэр талыг дүгнээд байх зохимжгүй.

Тэгэхдээ өнөөдрийн Байнгын хорооноос өгч байгаа тогтоол ерөнхий хуулийн хүрээндээ хуулийн хэрэгжилтийг хянаад явъя гэдэг дээр зөв байх. Агуулгын хувьд. Би нэгдүгээрт тэрийг хэлмээр байгаа юм.

Тэгэхээр нийслэл хэчнээн төгрөгийн авто замын үнэлгээтэй болоод байна? Үнэлгээ хэд байгаа вэ? Ерөнхийдөө чанарын үзүүлэлтээр нь замыг 5 ангилж байгаа байх. Ямар түвшинд ороод байгаа замууд байна?

Хоёрдугаарт, авто замын ашиглалт гэдэг зөвхөн нэг ийм дээрээс нь асфальт хучих биш. Ер нь замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, энэ дээрх тэмдэг, тэмдэглэгээг сайжруулах, зам тээврийн ослоос урьдчилан сэргийлэх. Магадгүй хөдөлгөөнд оролцож байгаа автомашин өмчлөгчийн автомашины эд анги эвдрэхээс хүртэл урьдчилан сэргийлж байгаа байхгүй юу. Дугуй, амортизатор. Өөр юу байдаг юм. Ер нь маш олон зүйлүүд эвдэрхий замтай болохоор эвдэрдэг. Бензин шатахуун зарцуулалтыг хүртэл багасгаж байгаа байх.

Тэгэхээр ач холбогдол талаас нь Та нар мэдээлэл өгөөч.

Ер нь ингэснээрээ зам тээврийн осол буурах уу? Машины эд анги, эвдрэл гэмтэл хэд дахин багасах тийм... /минут дуусав/

Ц.Даваасүрэн: Их Хурал хууль тогтоох, хяналт тавих онцгой бүрэн эрхтэй учраас ямар ч хуулийг аль ч шатад хяналт тавих эрхтэй. Хэн хариулах юм? 5 номер.

Т.Даваадалай: П.Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Засаг даргын нэгдүгээр оролцогч Т.Даваадалай.

Гишүүн гурав, дөрвөн асуулт тавилаа. Нэмээд тодруулаад манай Б.Одбаяр дарга хариулах байх.

Түрүүний хэлдгээр авто замын засвар, үйлчилгээг бага дээр нь хийхгүй бол цаашаа хүндрээд явдаг. Тэгээд 2022 онд хийсэн судалгаагаар шинэчлэл, их засвар хийх шаардлагатай нь 38 хувь. Тийм ээ. Ээлжит их засвар хийх шаардлагатай, тэгээд урсгал засвар хийх шаардлагатай гээд нийт авто замын түрүүн хэлсэн 82 хувь нь чанарын шаардлага хангахгүй байсан.

Үүнийг цаг тухайд нь засвар, үйлчилгээ хийж явахгүй бол яг нөгөө шүд цоорч эхлээд цаашаа хүндрээд явдаг шиг авто зам маань өөрөө бага хэмжээний гэмтэл аваад, цаашаа засвар, үйлчилгээнд нь хангалттай зардал тавьж хийхгүй бол хүндрээд явдаг. Хүндрээд явснаараа нэгдүгээрт, авто замын маань байдал маш хурдан мууддаг.

Хоёрдугаарт, иргэд дээр хувь хүний зардал нэмэгддэг. Ялангуяа дугуй, аваар осол, дээрээс нь засвар дээр.

2023 оны статистикийг авч үзэхэд Монгол Улс ойролцоогоор 500-аад тэрбум төгрөг автомашины сэлбэг хэрэгсэлд зарцуулагдаж байсан байна. Энэ зардлын ойролцоогоор 60-аас 70 хувь нь автомашины явах ангийн буюу авто замын гэмтлээс шалтгаалан гарч байна гэдэг статистик байсан.

Ийм учраас авто замын засвар, үйлчилгээг тогтмол, цаг хугацаанд нь хийх нь нэг талаасаа өөрөө замаа эвдлэхгүй, цаашаа нэмж зардал гарахгүй байх.

Хоёрдугаарт, иргэд аваар осолгүй, дээрээс нь автомашины эвдрэл дээр зардлыг бууруулах тооцоолол эндээс харагдаж байсан.

Авто замын үнэлгээ, нийт уртын талаар Б.Одбаяр дарга нэмээд хариулна.

Ц.Даваасүрэн: 3 номер. Б.Одбаяр.

Б.Одбаяр: Гишүүний асуултад хариулъя. Нийслэлийн замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр.

2022 онд хийгдсэн судалгаагаар нийт авто замынхаа хөрөнгийн үнэлгээг гаргаж байгаа. Хөрөнгийн үнэлгээгээр тухайн үед 1.8 их наяд төгрөг гэж гарч байгаа. Улаанбаатар хотын авто замын. Тэгээд хэрвээ бид хөрөнгийн менежментийг хэрэгжүүлэхгүй явах юм бол энэ үнэлгээ маань 5 жилийн дараа 750 руу бууж байгаа. 10 жилийн дараа гэх юм бол 652 тэрбум төгрөг хүртэл багасна гэж байгаа юм.

Тэгэхээр замын чанар, байдлын түвшинг өндөр түвшинд нь, PAVEMENT CONDITION INDEX_[хучилтын байдлын индекс] гэж байдаг. PCI буюу тэр нь 100 хувь байх юм бол шинэ зам гэж үзнэ.

Тэгээд шинэ замыг PCI буюу чанар байдлын индексийг нь бууруулахгүй явж байна гэдэг маань тухайн замын үнэлгээг бид анх баригдсан үнэлгээнд нь бариад л явж байна гэсэн үг. Энэ үнэлгээ маань 80-аас доошоо ирэх юм бол ер нь олон улс дээр 80 хувь дээр л барьж явдаг.

Ц.Даваасүрэн: Тодруулъя. П.Сайнзориг. Өөрөө нийслэлд ажиллаж байсан учраас энэ талаар сайн мэдэж байгаа байлгүй. Асуу асуу.

П.Сайнзориг: Би энэ Байнгын хорооны хуралд оролцож байгаа нь олон нийтдээ мэдээллээ сайн өгөөч ээ л гэдэг зүйлийг хэлэх гэж орж ирж байгаа юм.

Өнөөдөр 2010, 2011 оноос хойш бараа материал, ажиллах хүчний зардал хоёр дахин өсөөд байхад тухайн үед 400 километр замтай байсан нийслэл өнөөдөр 1200 километр.

Үүнийг арчлах зардал төдий чинээгээр өсөж байгаа. Тухайн үед нэг автомашин хэрэглэгч 700 мянган авто хэрэглэгчийн өмнөөс 2 сая хүн энэ замын арчилгааны төлбөрийг төлж болохгүй.

Дээрээс нь, жилд 5-аас 6 мянган километр явлаа гэхэд километр тутамд 3 төгрөгөөр хэрэглэж байгаа байхгүй юу. Приус автомашин эзэмшигч. Ийм хямдхан замтай орон байхгүй шүү дээ.

Тэгээд замын арчилгааг сайжруул гээд байгаа учраас үүнийгээ олон нийтдээ зөв ойлгуулж, шийдвэрээ танилцуулж, ач холбогдол болоод татварыг хэрэглэгч нь төлөөд явах ёстой гэдэг энэ концепцыг зөв ойлгуулах талаас нь нийслэлийнхэн нь анхаараач ээ гэдэг зүйлийг л хэлж байгаа юм. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Ж.Баясгалан гишүүн асуултаа асууя.

Ж.Баясгалан: Бүгдэд нь өдрийн мэнд хүргэе.

Нийслэлийнхэн одоо боль оо. Бид яг энэ юун дээр ч гаргасан байгаа шүү дээ. Чиглэл өгөх тухай дээр.

Бид та нарын тэр төсөвт ерөөсөө ороогүй. Үүнийг өсгөсөн нь зөв үү, буруу юу гэдэг дээр ороогүй. Энэ бол та нарын 100 хувь өөрсдийн чинь эрх мэдлийн асуудал.

Гол нь энэ хууль тогтоомжоо хэрэгжүүлэх явцдаа алдаа гаргасан уу, үгүй юу гэдгийг л асуугаад байгаа юм.

Тэр сонсгол хийсэн. 2 иргэн орсон гэж байна. 2 иргэн чинь нийслэлд байгаа сая гаруй хүнийг төлөөлж чадах юм уу?

790 мянган авто тээврийн хэрэгсэл татвар төлөгч гэж байгаа юм. Тэд нараа 2-хон иргэн төлөөлж чадах юм уу? Тэр 700 мянган татвар төлөгчөөс чинь хэдэн хүн тэр санал асуулгад орж байж үүнийг төлөөлөх ёстой юм?

Тэгээд хэдэн хүн тэрийг харсан юм? Тэр 2 хүн орсон. Хэдэн хүн харсан болоод 2-хон иргэн орж байгаа юм.

2024 оны 04 сард төсөвтэй холбоотой санал асуулга хийхэд бас оруулсан гэж байгаа юм. 2024 оны 04 сард авто замын татварыг өсгөнө гэж төсөвтөө тусгасан байсан юм уу? 2024 оны 04 сард сонгууль болох гэж байсан. Тэгж татварыг нь нэмсэн тийм дүнгээр оруулсан юм байхгүй байсан байх шүү.

Түүн дээрээ тэр дүн нь ороогүй. Сүүлд нь 12 сард оруулж ирэнгүүтээ тэгээд болохоор 04 сард 147 мянган хүнээс санал авсан гээд. 147 мянган хүн бол төсөвтэй холбоотой.

Яг энэ замын чинь төсөвтэй холбоотой тэр санал өгсөн 2-хон хүнээр ингэж энэ олон хүний асуудлыг шийдэх бол энэ бол буруу шүү.

Тэгээд татвар муугаас, бага байгаагаас болоод зам дээшээ, доошоо суугаад байна. Дээшээ, доошоо суусан чинь нэгдүгээрт татвар. Хийж байгаа тэр хөрөнгөтэй холбоотой, төсөвтэй холбоотой 1 километр замын.

Хоёрдугаарт, замын хийж байгаа компаниуд. Тэр чанар, хяналт шалгалттай холбоотой л байгаа шүү дээ.

Ноднин тэр танктай хөшөө хуучин, одоо тэмээтэй хөшөөний тэндэх зам хотгор, гэвгөр боллоо. Шинэ зам тавьсан чинь ийм боллоо гээд л нийслэлийнхэн маргааш нь гарч ирээд л, энэ замыг яаралтай засахаар боллоо. Хийсэн компани өөрсдөө алдаагаа ойлголоо л гэсэн. Одоо болтол тэр яг хэвээрээ л байгаа шүү дээ.

Тэгээд замын муугаас болоод машин эвдрээд байна гээд байна. Энэ зөв. Энэ бол иргэдийнхээ төлөө хийж байгаа зөв юм.

Тэгвэл та нар бас тооцоод үзсэн үү? Улаанбаатар хотод гарч байгаа зам тээврийн ослын хэдэн хувь нь замын нөхцөл байдал муугаас гэсэн шинжээчийн дүгнэлт гарсан юм. Яг хэдэн хувь нь. 1998 онд энэ нь ерөөсөө хоёрхон тохиолдол байсан юм шүү. Улаанбаатар хотод хоёрхон тохиолдол замын нөхцөл байдал муугаас гэж гарч байсан.

Тэгэхээр одоо хэдэн хувь байгаад тэгээд үүнийгээ ингээд байгаа юм. Тэгээд хамгийн гол нь тэр 2 хүнтэй тэр холбоотой асуудал дээр бүр яг тодорхой хариулаад өгөөрэй.

Ц.Даваасүрэн: Хэдэн номер вэ? 7 номер. Ж.Баясгалан гишүүний асуултад хариулъя.

М.Үнэнбат: Ж.Баясгалан гишүүний асуултад хариулъя.

Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газрын дарга М.Үнэнбат.

Ер нь аливаа захиргааны хэмжээний актыг гаргахын тулд гол харгалздаг зүйлүүд байдаг. Хамгийн гол зүйл эрх зүйн талаас нь байдаг. Энэ юу байна вэ гэхээр тухайн эрх зүйн хэм хэмжээг гаргах, эрх олгогдсон зохицуулалт байна уу гэдгийг харах ёстой.

Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага нь хуулиар тогтоосон хэм хэмжээний хүрээнд татвар тогтоох эрх нь нэгдүгээрт байгаа. Үүнийг бид бүхэн харсан.

Хоёрдугаарт, Захиргааны ерөнхий хуульд заасны дагуу хэм хэмжээний актыг гаргахад сонирхлын зөрчилтэй хүмүүсийн хэлэлцүүлгийг зохион байгуулах болох ёстой.

2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр Хүүхдийн ордонд хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Уг хэлэлцүүлэгт 9 дүүргийн 242 иргэн хамрагдсан. Тухайн хамрагдсан иргэдэд танилцуулсан зүйл нийслэлийн төсөв хэрхэн бүтэх юм бэ. Үүнд юу юу нөлөөлөх юм гэдэг талаар тодорхой ярьсан.

Тэр 2 иргэний тухайд. Цахимаар байршуулсан. Санал авахад ерөнхийдөө 2 иргэн саналаа ирүүлсэн байгаа.

Энэ дээр нэг зүйлийг гишүүнд тодруулаад хэлэхэд бид бүхэн цахимаар асуудлыг ингэж нээлттэй байршуулаад. Бид 2 иргэн ирсэн байна уу, 20 иргэн ирсэн байна уу, 200 иргэн ирсэн байна уу гэдгийг.

Одоо 200 иргэн ирээгүй учраас үүнийг гаргах ёсгүй юм гэдэг ийм эрх зүйн зохицуулалт байхгүй. Хамгийн гол нь хэлэлцүүлэг зохион байгуулахад 240 хүн ирсэн. Тэр хүрээнд энэ асуудлыг ярьсан.

Ц.Даваасүрэн: Уучлаарай. Хэлэлцүүлэг чинь тэр төсөв хэлэлцэхтэй холбогдолтой байсан юм биш үү. Яг үүгээр биш.

М.Үнэнбат: Төсөв бол тухайн 2025 оны нийслэлийн төсвийг ярихын тулд орлого нь ямар байх юм, зарлага нь ямар байх юм. Асуудал заавал яригддаг.

Тийм учраас орлогыг яаж бүрдүүлэхийн тулд татварын асуудал шууд яригдана, хамгийн түрүүнд яригдана.

Ц.Даваасүрэн: Үгүй үгүй. Энэ тогтоол чинь 2025 оны 06 дугаар тогтоол байхгүй юу. Аль төсөв батлагдсаны дараах.

Тэгэхээр төсөв хэлэлцэж байх үед татвар нэмэгдэх тухай юм ерөөсөө яваагүй шүү дээ. Одоо жишээлбэл танай дээр бид 2025 оны төсөв ярихад авто тээврийн хэрэгсэл дээр нийслэл дээр ийм орлого нэмэгдэж байна гэдэг юм ерөөсөө манайд орж ирээгүй шүү дээ.

М.Үнэнбат: 2024 оны 12 сарын 04-нд энэ татвар, асуудлыг баталсан. Иргэдийн хурлаас. Ингэхдээ 11 сарын 20-ны өдрийн хэлэлцүүлгийн үр дүнг.

Одоо хамгийн гол нь захиргааны хэм хэмжээний актыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгүүлэхэд хардаг хамгийн чухал зүйл бол иргэдийн оролцоог

хангасан байдлыг хардаг. Тэгж байж хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэдэг.

Гишүүддээ зүгээр нэг статистик мэдээ хэлэхэд 2013 оноос саяныг хүртэл татварыг нэмээгүй.

•2013 онд Улаанбаатарын замын сүлжээний урт нь 415.4 километр байсан.

•Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 192 мянган төгрөг байсан.

•Тээврийн хэрэгслийн тоо 410 мянга байсан.

•Засвар арчлалтын төсөвт өртөг нь 55 мянга байсан.

➢ Өнөөдрийн байдлаар Улаанбаатарын замын сүлжээний урт нь 1231.3 километр.

➢ Хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 792 мянган төгрөг.

➢ Тээврийн хэрэгсэл нь 804 мянга.

➢ Засвар арчлалтын төлбөр нэг дахин нэмэгдсэн. 110 мянга байгаа.

Дээрээс нь нэмээд нэг зүйлийг Та бүхэндээ хэлэхэд өнөөдрийн татвар нэмэгдсэн зүйл 3500-аас дээш буюу өндөр хүчин чадалтай машины татвар өндөр нэмэгдсэн байгаа.

Доошоо буюу 1500-аас 3100-гийн хоорондох татварын зөрүү авто тээврийн өөрөө явах тээврийн хэрэгслийн улсын албан татварын зөвхөн дунджаар авсан байгаа. Таазанд нь тулгаагүй гэсэн үг. Дээшээ дахиад ч тулгах бололцоо нь байгаа.

Та бүхэн судалгаан дээр гаргаж харсан байх. Яагаад гэхээр энэ... /минут дуусав/

Ц.Даваасүрэн: Та нарын тайлбар бол 2024 оны 12 дугаар сарын 04-ний өдөр тогтоол гарсан.

2024 оны иргэдийн Төлөөлөгч Хурлаар төсөв батлагдахад энэ татварын асуудал туссан байсан гээд байгаа юм байна. Тийм үү? Тэр туссан байсан учраас 2024 оны төсвийн хэлэлцүүлэг дээр яригдсан л гэж үзээд байгаа юм байна шүү дээ. Тийм ээ.

Та нар тийм протокол байгаа бол ажлын хэсэгт ирүүлсэн юм бий юу? Яг энэ татвартай холбогдолтойгоор.

Хэдэн номер хариулах юм? 7.

М.Үнэнбат: Ажлын хэсэгт эдгээр мэдээллийг бүгдийг нь өгсөн. Яг саяын байдлаар процесс явсан. Процессын алдаа энд гараагүй. Яг л бид бүхэн.

Энэ дээр хэрвээ процессын алдаа гарсан бол улсын нэгдсэн бүртгэлд бүртгэх боломжгүй. Бүртгэж аваагүй бол энэ хуулийг дагаж мөрдөх эрх зүйн үндэслэл байхгүй. Энэ хэм хэмжээний актыг.

Тийм болохоор...

Ц.Даваасүрэн: Би яагаад дахин дахин асуугаад байна вэ гэвэл одоо энэ чинь нийгэмд явах мэдээлэл нь болохоор иргэдээс цахимаар асуусан. 2-хон хүн ирсэн. Тэр нь иргэдийг төлөөлөхгүй гэдэг юм явах гээд байгаа учраас би тодруулаад байгаа юм шүү.

Тийм учраас Та бүхэн энэ дээрээ тодорхой хариулаарай.

Д.Пүрэвдаваа гишүүн асуултаа асууя. Тодруулах юм уу? Ж.Баясгалан гишүүн тодруулаад. Дараа нь Д.Пүрэвдаваа гишүүн асууя.

Д.Пүрэвдаваа: 04 сард татварын санал асуулга дээр орсон гэсэн шүү дээ. Тийм ээ.

Тэгэхээр тэр материалаа, одоо сая 7 номероос тэгж ойлголоо шүү дээ. Иргэдээсээ асуугаад, батлуулаад, тэгээд 12 сард оруулж ирсэн гэж.

Түрүүн хэлэхдээ 04 сард 147 мянган иргэнээс асуусан гэсэн.

Тэгэхээр тэрийгээ яг цаасаар, албан бичгээр над руу явуулаарай.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсэгт өгсөн юм биш үү. Сая чи өгсөн гэж хариулсан уу, үгүй юу?

Ж.Баясгалан: Тэгсэн. Тэр дээр байхгүй байна лээ. 2024 оны татвар дээрх байхгүй. Тийм ээ. 2024 оны татварын.

Ц.Даваасүрэн: Та нарын хэлээд байгаа материал дотор байхгүй гэж Ж.Баясгалан гишүүн хэлж байна шүү.

Ж.Баясгалан: Тийм.

Ц.Даваасүрэн: Үгүй үгүй. Та нар өөрсдөө тэр Хууль зүйн яам руу өгсөн учраас өөрсдөө авчирч өг. Түүнээс биш бид Хууль зүйн яам руу гүйгээд явж байх юм байхгүй шүү дээ.

Ж.Баясгалан гишүүн тодруулъя.

Ж.Баясгалан: Тэрийгээ нэгдүгээрт өгөөрэй.

Хоёрдугаарт гэх юм бол сүүлд 12 сарын 04-нд яг үүгээрээ дагнасан тэр хүүхдийн оронд хэлэлцүүлэг явуулсан гээд байгаа юм уу, эсвэл нийслэлийн татвартай холбоотойгоор тэр дунд нь энэ асуудал яригдсан юм уу? Нийслэлийн төсөвтэй холбоотойгоор яригдсан юм уу?

Яг энэ асуудлаараа нөгөө дагнасан тэр санал асуулгыг л бид яриад байгаа шүү дээ. Түүгээрээ санал асуулга авсан юм уу? Яг тэр цахимаар авсан 2-хон хүн чинь яг үүнтэй холбоотой асуудлаараа. Бусад нь ерөөсөө төсвөө үүнтэй холбоод байгаа юм уу? Төсөвтэй хийсэн асуудлаа нийслэлийн тээврийн хэрэгслийн татварыг тэр дээр ярьсан. Тэнд нэг буланд нь байсан гэж ярих гээд байгаа юм уу?

Ц.Даваасүрэн: 5 номерын микрофон хариулъя.

Т.Даваадалай: Ж.Баясгалан гишүүний асуултад нэмэлт тодруулга өгье. Т.Даваадалай Засаг даргын нэгдүгээр орлогч.

2024 оны 04 сараас 06 сарын санал асуулгад нь авто тээврийн хэрэгслийн талаар ороогүй байсан.

Яг тусгайлан нөгөө хуудсаар санал авдаг болохоор 10 сарын 18-нд 2 хүний санал ирсэн гэж байгаа.

Харин 11 сард Соёлын төв ордонд 242 хүний оролцоотойгоор хийсэн хэлэлцүүлэгт энэ татварын нэмэлтийн асуудал тусгагдсан байсан. Тус хэлэлцүүлгүүдээр бас иргэдээс үүнтэй холбогдолтой санал асуулгууд ирсэн.

2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол дээрээ авто зам ашигласны татвар нь 100.6 тэрбумаар, тээврийн хэрэгсэл болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын татвар нь 120.2 тэрбумаар нэмэгдэхээр танилцуулгадаа ороод, тэр нөгөө Хүүхдийн ордонд хийсэн 242 иргэнтэй хэлэлцүүлэг дээр ороод санал асуулга дээр нь явсан гэсэн үг.

Ц.Даваасүрэн: Яах вэ, ингээд л байсан л гэж байгаа юм байна. Одоо нөгөө төсөв дагасан хууль гэдэг шиг л юм болоод байгаа байхгүй юу. Байгаагүй биш байсан байдаг. Тэгэхдээ тэнд нь нэг их тийм мэдэгдэхээргүй, ард түмэн олж харахааргүй юм явсан байж магадгүй л юм байна.

Ж.Баясгалан гишүүн дутуу хариулсан учраас тодруулъя гэж байна.

Ж.Баясгалан: Тэгэхээр ерөөсөө авто тээврийн татварыг нэмэхтэй холбоотойгоор яг бие даагаад явсан ганцхан л тэр цахим л байгаа юм байна шүү дээ.

Та нар яг хэлчих л дээ. Яг бие даагаад явсан. Ерөөсөө цахимаар ганц асуугаад л, түүнд нь 2 хүн оролцсон юм байна. Түүнээс биш тэр 400 хүн оролцсон, 200 хүн оролцсон тэр хэлэлцүүлэг дээр чинь тэр асуудал тусгагдсан байсан болохоос биш дагнасан түүгээрээ санал асуулга явсан, хэлэлцүүлэг явсан юм байхгүй л юм байна шүү дээ.

Тэгээд одоо ингээд энэ дээрээ болонгуут тэгэхэд ч тэгсэн, 04 сарын төсөв дээр орсон. Одоо болохоор ороогүй гээд тэгж байна. Тэгээд ерөөсөө л үнэн л юм байна шүү дээ. 2-хон хүний санал асуулга л явсан юм байна шүү дээ. Бие даасан. Тийм байгаа биз дээ. Бусад нь тэр төсөвт л тэр асуудал тусгагдсан байсан. Түүнийгээ ард иргэд харахгүй яасан юм бэ л гэсэн утгатай юм хэлээд байна шүү дээ.

Ц.Даваасүрэн: Тийм тийм. Ер нь наадах чинь хөөе яг энэ хуулийнхаа дагуу бол тэр хууль тогтоол, шийдвэр гаргах гэж байгаа түүгээрээ хэлэлцүүлэг хийх тухай асуудал шүү дээ. Түүнээс биш гуя дагаж хүзүү гэдэг шиг төсвийн буланд явсан гэж бас болохгүй л болоод байна л даа.

Тэгээд энэ дээр нь хариулах хариулт байна уу? Тодорхой. 5.

Т.Даваадалай: Ж.Баясгалан гишүүний асуултад нэмээд хариулъя. Т.Даваадалай Засаг дарга нэгдүгээр орлогч.

Анх хуулийн төслийн саналыг бид 4 дахин нэмэгдүүлэхээр бэлтгэж байсан. Дээд хязгаарын дагуу.

Тэгээд 2024 оны 11 дүгээр сард хийсэн хэлэлцүүлгийн үр дүнд ойролцоогоор 15 иргэнээс санал асуулт ярилцсаны үр дүнд бид тухайн хэмжээг буцаж эргэн харж үзээд 3 дахин болгож татвар дээр хэлэлцүүлгийг хийсэн.

Тэр 2024 оны 10 сарын 18-ны өдөр яг тусгайлан энэ дээр бас авто тээврийн хэрэгсэл дээр санал асуулга явуулж 2 хүн дэмжихгүй гэсэн санал өгсөн.

Тэгэхээр эдгээр санал асуулгыг авч үзээд бид 3 дахин болгож бууруулж оруулсан байгаа.

Тэгэхээр тусгайлан хэлэлцүүлэг явсан гэж үзэж байгаа.

Ц.Даваасүрэн: Яах вэ, тусгайлан хэлэлцүүлэг цахимаар явсан л юм байна л даа. Тэгээд 2-хон хүн ирсэн. Үгүй тэгээд тэр нь бас нөгөө хуулийн зохицуулалтгүй болоод байгаа юм байна шүү дээ.

Одоо иргэдийн тэдэн хувь нь оролцож байж хүчинтэй болно гэсэн заалт байхгүй л юм байна л даа.

Д.Пүрэвдаваа гишүүн.

Д.Пүрэвдаваа: Ингэмээр байна.

Нэгдүгээрт, нийслэлийн авто зам эвдэрсэн байгаа юм, хөрөнгө мөнгө хэрэгтэй гэдэгтэй маргасан хүн байхгүй. Ажлын хэсэг дээр.

Нийслэлийн авто замын 60 орчим хувь нь нэлээн хүнд гэмтэлтэй. Тэдэн хувь нь арай дунд зэргийн гэмтэлтэй. Жил болгон л энэ асуудал нийслэлийн Иргэдийн Хурал дээр яригддаг.

Энэ жил онцгой жил. Нийслэлийн төсөв гэх юм бол хөрөнгө оруулалтын төсөв нь одоо жишээгээр өмнөх жилүүд 400, 500 тэрбум төгрөг байхад бид их төсөв батлагдлаа гэдэг байсан бол 2025 онд улс болон нийслэлийн нийт хөрөнгө оруулалтын төсөв хэдэн их наядаар яригдах хэмжээнд очсон шүү дээ.

Тэгээд төсөв нэмээд яасан бэ. Татвар нэмсэн үү. Энэ бол татвар, хураамжийн асуудал мөнөөсөө мөн.

Тэгэхээр 50 тэрбум ордог байсныг 150 болгож нэмэгдүүлсэн. Түүнийгээ авто замын санд оруулаад зарах асуудал яригдсан. Зөв биз дээ. Нэг үнэн.

Дараагийн нэг үнэн юу вэ гэх юм бол нийслэл өөрсдийнхөө хүссэн зүйлээ маш олон мэдээллийн хэрэгслээр болон цахим хуудсаар сурталчлах ажил өнгөрсөн жил хангалттай хийгдэж байсан.

Дээрээс нь хэлье. Эрх зүйн хувьд төрийн албан хаагч хууль дээдлэх зарчмыг баримталж ажиллана. Хоёрдмол утгатай байж шийдвэр гаргаж болохгүй. Хууль тогтоомжийн тухай хуульд байгаа биз. Төрийн албаны тухай хуульд байгаа. Тийм үү. Дээрээс нь Татварын ерөнхий хууль дээр юу гэж татвар төлөгчийн эрх яаж байдаг юм. Ялангуяа энэ шийдвэр гаргасан хүмүүсээс. Одоо маш тодорхой хариулах хэрэгтэй.

Татвар төлөгч ямар эрх эдэлдэг юм. Татварын ерөнхий хуулиар. Тэрийг нь зөрчсөн тохиолдолд ямар хариуцлага үүрдэг юм бэ гэдгийг одоо хариулаадах.

Хоёрдугаарт, Мэдээллийн ил тод байдлын тухай хуульд тийм үү, зорилго нь юу байдаг юм, нийслэлийн хэм хэмжээ хамрагддаг юм уу? Үүнийг зөрчсөн тохиолдолд яадаг юм? Та хариулаадах. Тэгээд би нэмэлтээр тодруулна.

Ц.Даваасүрэн: Х.Ганхуяг гишүүн ажлын хэсэг биш учраас болохгүй юм байна шүү. Хэдэн номерын микрофон хариулах гэж байна. 7 хариулъя. Тодорхой хариулаарай. Саяын асуусан хоёр, гурван асуултад.

М.Үнэнбат: Хууль тогтоомж, гэрээ, эрх зүйн газар. М.Үнэнбат.

Ц.Даваасүрэн: Микрофоноо жоохон өөр лүүгээ татчих.

М.Үнэнбат: Аливаа иргэн татвар төлөх үүрэгтэй. Энэ хүрээндээ тогтоосон хууль тогтоомжийн хүрээнд гаргасан татварыг төлөх нь энэ бол татвар төлөгчийн үүрэг. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, аливаа шийдвэр хуулийн дагуу гарах ёстой. Ингэж байж тэр хууль дээдлэх гэдэг зарчим хангагддаг.

Үндсэн хуульд аливаа татварыг хуулиар тогтоосон хэмжээнд тогтоох эрх нь Үндсэн хуулиар иргэдийн хуралдай байгаа. Энэ бол нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагыг бэхжүүлэх маш том зохицуулалтын нэг.

Энэ хүрээндээ татварын татварын хэмжээ тогтоосон актыг баталсан.

Дахиад би энд нэг зүйлийг тодруулаад хэлэхэд цилиндрийн багтаамж өндөр машинуудын татвар нэмэгдсэн. Цилиндрийн багтаамж 3500-аас доошоо бол дунджийг нь баримталсан. Одоо би нэг жишээ хэлэхэд 2-оос 3 тонны даацтай машины жилийн татвар 135 мянган төгрөг байгаа. Бид нарын ярьдгаар портер. 100 айл дээрээс Хандгайт байдаг юм уу, хойшоо зуслангийн бүс рүү нэг удаагийн тээвэр хийхэд 150 мянга доор хаяж байгаа.

Тэгээд энэ бүрчлэн бид бүхэн захиргааны хэмжээний акт гаргахдаа хэм хэмжээний акт болон бусад зүйлүүдийг бүгдийг нь харгалзаж үзсэн.

Хууль дээдлэх тухай Та хэллээ. Бид бүхэн хуулийн хүрээнд татварын хэм хэмжээний актыг батлах энэ бүх процесс явсан гэдгийг танд хэлье.

Ц.Даваасүрэн: Д.Пүрэвдаваа гишүүн тодруулъя.

Д.Пүрэвдаваа: Би Та бүхэндээ. Ингэмээр байна. Нийслэлийн иргэдийн хурлын LEGACY буюу хүлээн зөвшөөрөгдөх байдал муу байгаа учраас өнөөдөр 30 мянган иргэн гарын үсэг зураад нэг иргэнийхээ санал дээр орж ирсэн асуудал байхгүй юу даа.

Нийслэлийн иргэдийн Хурлын үүд хаалга хаалттай байгаа учраас Улсын Их Хурлын одоо энэ цахим нээлттэй байдалд орж ирээд хүмүүс 30 мянган хүн нэг доороо нэг сарын хугацаанд гарын үсэг зурсан.

Энэ нь юуг илэрхийлж байна вэ гэхээр зэрэг ил тод байдал байхгүй байна гэсэн үг.

Тэгээд би танд хэлье. Татварын ерөнхий хуулийн 10 дугаар зүйлийн 1.8 дээр татвар ногдуулах болон хөнгөлөх, чөлөөлөхтэй холбоотой хууль, тогтоомж,

шийдвэрийн төсөлд санал өгөх эрхтэй. Татвар төлөгчийн үндсэн эрх... /минут дуусав/

Ц.Даваасүрэн: Сунгая. Дутуу хариулсан учраас 1 минутыг нь сунгаж өгье дөө. Д.Пүрэвдаваа гишүүний микрофоныг.

Д.Пүрэвдаваа: Тэгэхээр би та нараас асуусан. Маш ойлгомжтой. Та хуульч хүний хувьд хариулах ёстой.

Хүний хуулиар олгогдсон эрх хийг Та зөрчсөн тохиолдолд тийм үү, үүнийг хэрхэн залруулдаг юм, яаж хохирлыг тооцдог юм бэ гэж асуусан. Та тэгэхэд өөдөөс портер яриад бүр хадуураад явчихлаа. Нэг.

Хоёрдугаарт, дахиад нэг юм хэлье. Нийслэлийн ямар нэгэн асуудлаар дахиад иргэд 30 мянга, 40 мянгаараа гарын үсэг зураад ороод ирвэл яах юм. Мдээллийн ил тод байдлын тухай хууль чинь хэрэгжихгүй байна. Бид нарын эрх ашиг зөрчигдөөд байна гээд Улсын Их Хуралд хандаад байвал уг нь нийслэл өөрөө энэ дэгдээ ч гэдэг юм уу, өөрсдийн тэр шийдвэр гаргах дотоод журамдаа өөрчлөлт оруулаад иргэдээ сонсох энэ үүд хаалгыг маш томоор нээж өгөх ёстой байна гэдгийн л илрэл байхгүй юу даа.

Ц.Даваасүрэн: Ажлын хэсгийн даргыг оруулж ирье.

Одоо жишээлбэл асуусан гээд, хэлэлцүүлэг хийсэн гээд байгаа тэр нэг цахимын асуудлыг нь хэр судалсныг ажлын хэсэг хариулмаар байна. Ажлын хэсэг. Үнэхээр иргэд өөрсдөө идэвхгүй, оролцоогүй бол яах юм бэ? Тийм.

Зүгээр хаалттай юман дээр тавьсан байсан юм уу? Тэрийг нь бас нэг ажлын хэсэгт нягталсан байх хэрэгтэй. 7 номер хариулъя.

М.Үнэнбат: Тэгэхээр гишүүний асуултад хариулъя.

Бид бүхэн хэрвээ ямар нэгэн шийдвэргүйгээр иргэний карманаас мөнгө аваад, татвар авсан бол энэ хууль зөрчсөн асуудал болно. Хуулийн дагуу, бүх хэм хэмжээний хүрээнд татвар тогтоон ногдуулаад энэ татварыг авсан.

Хоёрдугаарт, би дахиад хэлэхэд 11 сарын 20-ны өдөр хэлэлцүүлэг зохион байгуулахдаа энэ асуудлыг ярьсан.

Тийм учраас бид бүхэн яг хууль зөрчсөн юм байхгүй. Нэгэнт хуулийн дагуу гарсан зүйлийг татвар төлөгч бүрэн төлөх үүрэгтэй.

Нэмээд хэлэхэд аливаа хүн татвар төлөх, сайн дураараа татвараа төлье... /минут дуусав/

Ц.Даваасүрэн: Яах вэ, ер нь ингээд байна. Т.Аубакир гишүүн ээ, та ажлын хэсгийн даргын хувьд л нэг цэг тавихаас.

Нийслэл болохоор хэлэлцүүлгийг хуулийн дагуу хийсэн. Иргэд нэг ирнэ үү, хоёр ирнэ үү. Тэр бол тэдний идэвх, оролцооны асуудал. Тэдэн хувь нь ирж байж иргэдийн оролцоо хангагдана гэсэн тийм эрх зүйн зохицуулалт байхгүй ээ.

Тэгэхээр бид цахимаар авсан нь хуульд нийцэж байгаа юм гээд байгаа дээр ажлын хэсэг яг юу гэж үзсэн юм? Т.Аубакир гишүүний микрофон.

Т.Аубакир: Ажлын хэсэг дээр гол тавьсан асуудал бол татвар нэмсэн нь зөв, буруу гэдэг асуудал яриагүй.

Татвар нэмэхийгээ яг иргэдээсээ асуусан юм уу. Иргэд нь нэмэх нь зөв, эсвэл нэмэх нь буруу гэж хэлсэн юм уу л гээд байгаа юм. Манай нийслэлийнхэн болохоор 2 иргэн оролцсон гээд байгаа. 2 биш байлгүй дээ энэ чинь одоо. Эсвэл ерөөсөө.

Мэдээжийн хэрэг зүгээр яах вэ энэ зөвхөн миний бодол шүү. Ажлын хэсгийн биш. Татвар нэмье, нэмэх гэж байна шүү гэхээр тэгье гэж хэлэх хүн олдохгүй л дээ.

Тэгээд манай ажлын хэсгээс бид энд чиглэл өгөх гээд байгаа юм. Одоо энэ Засгийн газар луу байдаг ч юм уу. Тийм ээ. Засгийн газар луу л чиглэл өгнө л дөө. Яг энэ процессын алдаа гаргасан юм уу. Татвар нэмэх явцдаа, ямар нэг эрх зүйн акт гаргахдаа ард иргэдийнхээ саналыг сонссон сонссон юм уу. Тэрийгээ нотлоодох л гээд байгаа шүү дээ.

Яах вэ, бид нар луу бичиг баримт хүргүүлсэн. Ирсэн өдөр нь тэр даруй Б.Мөнхсоёл гишүүн, Д.Пүрэвдаваа гишүүн, Ж.Баясгалан гишүүн нарт би хүргүүлсэн байгаа. Туслахууд дээр нь байгаа байх. Гэхдээ эртээд бас дахиж хувилж өгсөн шүү дээ.

Ажлын хэсгээс чиглэл өгье. Энэ процесс дээрээ алдаа гаргасан юм биш үү гэдгийг нь Засгийн газар аяа л гэж байгаа. Энэ тогтоолоо хэдүүлээ батлаад яахгүй бол нөгөө иргэний 33 мянган хүний гарын үсэг зурсан. Их Хурал авч хэлэлцэх ёстой шүү дээ. Энэ заавал нэг дүгнэлт гаргана.

Хоёр л арга байна. Нэгдүгээрт, Засгийн газар луу чиглэлийг нь өгөөд энэ процессыг нь шалгаад татвар нэмэх одоо яг эдийн засгийн зайлшгүй шаардлага байсан юм уу, үгүй юм уу.

Хоёр дахь асуудал нь дахиж ажлын хэсэг байгуулагдаад, одоо бүр нарийвчлаад тэр иргэдийн Хурлын асуудал руу нь ороод л процессыг нь шалгахаас өөр арга байхгүй.

Ц.Даваасүрэн дарга аа.

Ц.Даваасүрэн: Ямар ч гэсэн ажлын хэсэг дүгнэлтдээ энэ хэлэлцүүлэг, сонсгол зөв, аль эсвэл хуулийн хүрээнд явагдаж уу, үгүй юу гэдэг дүгнэлт гаргаж чадаагүй юм байна.

Миний ойлгосноор Засгийн газрыг үүнийг нягталж оруулж ирээч ээ гэж байгаа юм байна шүү дээ. Тэгж ойлгоод хэдүүлээ асуултаа үргэлжлүүлээд явъя. Тийм.

Д.Батбаяр гишүүн асуултаа асууя.

Д.Батбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе.

Энэ ажлын хэсгийн хүргүүлж байгаа санал, дүгнэлтээс нэг параграф уншихъя.

Нийслэлийн авто замын сүлжээг өргөтгөх, шинэчлэх зорилгоор Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас 2024 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Улаанбаатар хотын автотээврийн албан татварын хувь хэмжээг 2012 оныхоос 3 дахин нэмэгдүүлжээ гэсэн байна.

Тэгэхээр энэ нэмэгдүүлснийхээ хүрээнд 132 тэрбум төгрөгийг авто замын санд төвлөрүүлсэн юм байна. Тийм үү. Зөв үү. Тийм ээ.

Тэгээд үүний зорилго нь яагаад татварыг нэмэгдүүлсэн бэ гэхээр нийслэлийнхээ авто замын сүлжээг ахиад өргөтгөөд, шинэчлээд явах нь зүйтэй байна. Тэгэх зайлшгүй шаардлага байна гэсэн ийм үндэслэлээр татвар нэмсэн юм байна шүү дээ. Тийм ээ. Зөв үү. Тийм ээ.

Тэгэхээр нэг ийм асуудал байгаад байна л даа. Бид чинь өнгөрсөн жилжингээ л ярьсан санагдаад байх юм. Нэг баахан бродюр тавиад л яваад байсан. Замын. Бараг Улаанбаатар хотын бүх бродюрыг сольсон санагдаад байх юм. Мөн үү. Тийм ээ.

Тэгээд 2024 оныхоо 02 дугаар сард татвараа нэмээд, замаа өргөтгөнө гэсэн зорилгоор татвар нэмж иргэдээс 132 тэрбум цуглуулаад, ахиад зунжингаа бродюр солиод одоо энэ төвлөрүүлсэн мөнгөөрөө ахиад замаа өргөтгөнө гээд явах юм уу? Энэ зөв үү? Энэ дээр хариулт авъя.

Ц.Даваасүрэн: 3 номерын микрофон хариулъя.

Б.Одбаяр: Нийслэлийн замын хөгжлийн газрын дарга Б.Одбаяр. Гишүүний асуултад хариулъя.

2024 оны 02 сарын байдлаар 132 тэрбум төгрөг төвлөрөөгүй. Би түрүүн таныг одоо 2025 оны байдлаар ямар хэмжээний мөнгө төвлөрсөн байгаа юм бэ гэж асуугаад буруу, үл ойлголцол үүсэх шиг боллоо.

2024 онд нийтдээ замын сан дээр авто замын татвар, авто зам ашигласны төлбөр, зогсоол бүгд нийлээд жилдээ 60-аас 70 тэрбум төгрөг л төвлөрдөг.

Өнгөрсөн жил 69.4 тэрбум төгрөг л төвлөрсөн. Үүгээр бид юу хийдэг вэ гэхээр шинэ замаа барьж байна. Шинэчлэлийн ажил явж байна. Ойролцоогоор 18-аас 20 километр зам л шинэчилдэг, засварладаг.

Өнгөрсөн жил баахан бордюр сольсон гээд байна. Өнгөрсөн жил цаг агаарын хувьд хүйтэрсэн учраас өнгөрсөн жил зарим хучилтууд хийгдээгүй. Энэ жил хийгдээд явж байгаа. Энхтайваны өргөн чөлөө явж байна, Их тойруу явж байна, ажилчин, Чингисийн өргөн чөлөө, Зайсангаас тэмээтэй хөшөө, Шар хадны эцэс, Доржийн гудамж, Денверийн гудамж, Жанжин клуб гээд бүх ерөнхийдөө нийт гол замынхаа бид 72 хувийг шинэчилж байна.

Тэгэхээр энэ дээр зөвхөн хашлага солиод явж байгаа юм ерөөсөө биш. Хашлагаа солино. Зам заавал засагдана гэсэн үг. Хашлага хэрвээ сольж л байгаа бол.

Одоо үүнээс цааш, түүнээс цааш нэгэнт чулуу болсон бол дахиж хашлага солино гэсэн ойлголт байхгүй. Дахиж 30, 40 жилдээ үнэхээр үүрээд л бутраад унахгүй гэж байгаа.

2006 он, 2007 онд Энх тайвны өргөн чөлөөний хашлагыг чулуу болгосон. Одоо 2025 онд бид засвар хийхдээ нэг ч хашлага солиогүй. 18 жилийн өмнөх байсан хашлага одоо хэвээрээ л байгаа. Яг үүнтэй адилхан чулуу болгох юм бол. Бетоноор хийх юм бол жил хүрэхгүй үүрээд унаж байна. Цементийн чанараасаа байгаа юм уу, давс, бодисоосоо байгаа юм уу жилийн дараа солих ч юм уу, 2 жилийн дараа үүрээд бутраад унадаг. Энэ байдлаас зөвхөн урт хугацаандаа чулуун хашлага бол үр ашигтай. Нэгэнт шинэчлэл хийж байгаа бол шинэчлээд дахиж ийм хашлага солихгүй.

Олон улсад ихэнх хашлагууд бүгд л чулуугаар байгаа. Бетоноор хийх ялгаа нь үүрээд л унаж байгаатай адилхан.

Ц.Даваасүрэн: Ойлголоо. Яах вэ, манайд чинь ерөөсөө юм хийж болдоггүй байхгүй юу. Нэг юм хийхээр л нөгөө талаас нь муулаад л байдаг. Ер нь хийсэн хүн муулуулаад байна. Хийгээгүй хүн яадаг ч үгүй. Энэ бол Монголын хууль.

Тийм учраас эмзэглээд хэрэггүй. Ер нь зүгээр эд нар жоохон эмзэглээд байна л даа. Үөв л байх л даа. Удаан хугацаагаар эдэлгээтэй.

Зүгээр нэг бордюрын мөнгө идлээ гээд л нийгэмд сүлжээгээр цацчихаж байгаа байхгүй юу. Тэгэнгүүт нөгөөдөх нь тахал шиг яваад л. Ерөөсөө юм хийхэд хүндрэлтэй.

Г.Ганбаатар гишүүн асуултаа асууя.

Г.Ганбаатар: Манай Төсвийн байнгын хорооноос ажлын хэсэг гараад бас нэлээн шаргуу ажилласан байна. Яах вэ, бид нарын яриад байгаа зүйл бол энэ нийслэл дээр ер нь ил тод байдал хэр байна вэ, иргэдийн оролцоо ямар байгаа юм, шийдвэр гаргалт нь ер нь яаж гараад байгаа юм, жоохон нөөцөө байна. Санхүүгийнхээ нөөцийг хэр зөв зарцуулж байна вэ гэдэг л асуудал яриад байна л даа.

Тэгэхээр гурван асуулт би эхлээд асууя. Асуухаасаа өмнө би та нарт нэг зүйл, нэг түүх гэх юм уу даа.

Би Дорноговь аймгийн иргэдийн Хурлын даргаар 8 жил ажилласан юм. Ажиллаж байх хугацаандаа би “Иргэдийн оролцооны төв” гэж байгууллагад иргэдээ байгуулаад тэр нь олон улсын Швейцарын хөгжлийн агентлагаас маш их дэмжлэг аваад, одоо аймгуудад бас нэлээн аятайхан болоод явж байх шиг байгаа юм.

Тэнд Дорноговь аймгийн Сайншанд сумын бүх сумдын иргэдийн гар утасны дугаарыг хуулийнх нь хүрээнд аваад, аливаа асуудал хэлэлцэх гэж байхдаа бид хүн амын орлоготой холбоотой, дээрээс нь нөгөө үл хөдлөх хөрөнгийн татварын интервалтай холбоотой олон асуудлуудыг нэг кноп дарахад бүх аймгийн иргэдэд очдог байсан байхгүй юу. Ийм асуудал хэлэлцэх гэж байна, аймгийн иргэдийн Хурал дээр. Та нар ирж саналаа өгнө үү гээд.

Тэгэхээр та нарын яригдаад байгаа энэ зүйл аягүй тийм нэг бодлын. Одоо ийм их. Миний яриад байгаа зүйл чинь одоо бараг 14, 15 жилийн өмнөх юм шүү дээ. Тэгэхэд одоо ийм сошиал хөгжсөн ийм үед аягүй өрөвдөлтэй юм ярьж байгаа байхгүй юу. Нийслэл хариуцлагагүй байна.

12 сарын 04-нд нийслэлийн иргэдийн Хурлын тогтоол гарсан юм байна. Тийм ээ. Би буруу ойлгоогүй бол та нар 5 дугаар сард 147 иргэдтэй нэг уулзалт зохион байгуулсан юм байна. Тэр 11 сарын 20-нд 9 дүүргээсээ 240 иргэн зохион байгуулсан.

Нийтдээ 347 иргэн. Энэ чинь эрх ашиг нь хөндөгдөж байгаа талуудын хэдэн хувь бэ? Шийдвэр гаргалт чинь ер нь яаж явж байна вэ?

Түрүүнд өөрөө М.Үнэнбат гэсэн байх аа. Хууль, эрх зүйн газрын дарга. Би өөрөөс чинь гурван зүйл асууя.

Нэгдүгээрт нь, тэр 12 сарын 04-нд гаргасан иргэдийн Хурлынхаа тогтоолыг Хууль зүйн яаманд хэзээ бүртгүүлсэн юм?

Хоёрдугаарт нь, саяын миний асууж байгаа давхардаж байх шиг байна. Тэр 240 болоод 147, энэ 347 хүн гэдэг чинь ер нь эрх ашиг нь хөндөгдөж байгаа хэдэн хувь нь вэ? Одоо нийт иргэдийн, энэ татвар төлөгчдийн, зам ашиглагчдын.

Та нар үүнийг бодож үзсэн үү?

Гуравдугаарт нь, хэрвээ та нар түрүүнд манай хэн гишүүн хэлэв. Энэ шийдвэр гаргалт чинь их зөв байсан бол өнөөдөр Төсвийн байнгын хорооноос ажлын хэсэг гаргаад, иргэдээс гомдол ирээд, тэгээд 33 мянган гарын үсэг зураад өнөөдөр бид ингээд хэлэлцээд сууж байх уу? Энэ шийдвэр гаргалтын чинь байдал ер нь яг ямар байна вэ? М.Үнэнбат дарга аа. Миний гурван асуулт энэ шүү.

Б.Одбаяр гэсэн байх аа. Тийм ээ. Өөрөө замын газрын. Тэр хөрөнгийн менежментийн зардалд тэр хэрэглээ талаасаа, мөн дээрээс нь хэн илүү зарцуулж, хэн илүү зам ашиглаж... /минут дуусав/

Ц.Даваасүрэн: Хариулж эхэлъя. 7 номер гурван асуулт. Дараа нь тэр хөрөнгийн менежмент 2 номер. 7 номерыг өгье.

М.Үнэнбат: Г.Ганбаатар гишүүний асуултад хариулъя. Хэдэн хувь бэ гэж асууж байна.

Ер нь өнөөдрийн байдлаар нийслэл Улаанбаатар хотод 1.7 сая иргэн байгаа. Яг бүртгэлтэй машин 800 гаруй мянган машин байгаа.

Тэгэхээр 800 гаруй мянган хувиас нь тооцож үзэх юм бол 300 гаруй иргэн гэдэг бол мэдээжийн бага тоо. Тэгэхдээ нэг зүйлийг бид бүхэн бодох ёстой гэж бид бодож байгаа юм. Юу гэхээр өнөөдрийн хэм хэмжээний акт гаргах хүрээнд нийт 800 мянган эрх ашиг нь хөндөгдөж байгаа хүний 10 хувиас нь саналаа аваад наадахаа батал гэдэг юм байвал бид хамаагүй тэгээд явах ёстой. Өнөөдрийн хэмжээнд тийм зүйл байхгүй. Нэгд.

Хоёрдугаарт, цахимаар бид бүхэн тавиад, дээрээс нь хэлэлцүүлэг хийгээд иргэдийн. Одоо бүх хүмүүсийг ирээд та нар саналаа хэл гэх боломж байхгүй. Энэ угаасаа энэ бүгдээрээ оролцох боломж байхгүй.

Таны саяын тэр шууд иргэдэд мессежээр хүргэдэг гэдгийг бид бүхэн цаашдаа ажил сайжруулах үүднээс аваад явахад их сайхан санаачилга байна гэж бодож байна.

Хоёрдугаарт нь, Их Хурлын хуульд орсон бас нэг том бодлогын асуудал бол иргэдийн санал авдаг процесс байдаг. 30 мянга, 70 мянга, 100 мянга гээд. Энэ хүрээндээ иргэд 33 мянган хүн иргэд татвар нэмсэн нь буруу юм гэдэг санал гаргасан гэж ойлгосон.

Тэгээд иргэд энэ талаар саналаа, мэдээж татвар нэмэхэд “өө сайн”, “би дуртай”, “зөв байна” гэж ярих хэсэг байх хэдий ч масс бол “энэ буруу” л гэдэг дээр байна байх гэж ойлгож байгаа.

Тэгээд би түрүүнд хэлсэн. Анх 2013 онд хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 192 мянган төгрөг байсан. Өнөөдөр 792 мянган төгрөг. Энэ хоорондын харьцаа 4 дахин өөрчлөгдөөд байгаа. Энэ 4 дахин өөрчлөгдсөн хүрээнд нь бид яг эцсийн таазыг нь тулгаагүй. Заримынх нь дунджаар, заримынх нь гуравны хоёроор татвараа нэмсэн ийм л зүйл байгаа.

Гуравдугаарт нь, Хууль зүй, дотоод хэргийн яаманд хэм хэмжээний актыг хүргүүлдэг энэ Захиргааны ерөнхий хуульд заасан тодорхой заасан зохицуулалтууд байдаг. Энэ хүрээндээ бид бүхэн 2024 оны 12 сарын 31-ний өдөр хүргүүлсэн. Бүх материалаа хүргүүлсэн. Хууль зүйн яам хянаж үзээд хэрвээ бид бүхэн хууль тогтоомж зөрчсөн юм уу, аль нэгэн процессын алдаа гаргасан бол Хууль зүйн яамнаас зөвлөмж ирдэг. Наадах чинь буруу байна. Үүнийгээ эргэж хар. Бид бүртгэж авахгүй нь. Бүртгээгүй учраас энэ нь хууль бус шүү гэдэг зөвлөмжийг тухайн хэм хэмжээний акт гаргадаг байгууллагад ирүүлдэг. Бид бүхэн хүргүүлсэн. Хууль зүйн яам бүгдийг нь хянаж үзээд боломжтой байна гээд улсын бүртгэлийн нэгдсэн санд бүртгэж авсан.

Тэгэхээр ийм л процесс болсон. Таны гурван асуултад хариулахад ийм л.

Ц.Даваасүрэн: 3 номер. Тэр хөрөнгийн менежмент талаас нь. Санал юм байна. Тийм ээ.

Г.Ганбаатар гишүүн тодруулъя.

Г.Ганбаатар: Нийслэлийн Хууль эрх зүйн газрын даргаас.

Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын гаргасан шийдвэрийг хэрвээ хууль бус юм уу, ямарваа захиргааны акт зөрчсөн гэж үзвэл өөрөө хүчингүй болгодог, эсвэл дээд шатных нь байгууллага хүчингүй болгодог байсан.

Одоо тэр хуулийн заалт хэвээрээ байгаа юу? Өнөөдөр Төсвийн байнгын хороон дээр энэ асуудал яригдаж байгаа нь. Түрүүнд яах вэ, Байнгын хорооны

дарга Улсын Их Хурал гаргасан хуульдаа хяналт тавих бүрэн эрхтэй гэж байгаа юм.

Яг энэ асуудлаар бид энд ингээд ярьж байгаа нь хууль эрх зүйн талаасаа зөв үү?

Ц.Даваасүрэн: 7.

М.Үнэнбат: Гишүүний асуултад хариулъя. Үндсэн хуульд нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын хамгийн том бэхжүүлэх нэг суурь зохицуулалт бол энэ татварын хувь хэмжээг тогтоох асуудал байдаг. Их Хурлаас дээд таазыг нь тавьж өгдөг. Энэ хүрээндээ татвар тогтоох эрх нь нэгдүгээрт байгаа.

Хоёрдугаарт, өнөөдөр Их Хурал аль ч хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан шалгах эрхтэй хэдий ч Байнгын хорооноос гаргахыг бол нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагад энэ асуудлаа эргэж харах нь зүйтэй байх гэсэн зөвлөмжийн шинж чанартай зүйл гарах болов уу гэж бодож байгаа.

Яагаад гэхээр Үндсэн хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын шийдвэрийг аль нэгэн байгууллага хянаад эхэлбэл энэ маань Үндсэн хуулийн зөрчил рүү орж болзошгүй.

Ц.Даваасүрэн: Дээд шатын байгууллага нь хүчингүй болгоно гээд байгаа зохицуулалттай үйлчилж байгаа юу гэж асуугаад байна шүү дээ.

М.Үнэнбат: Энэ бол захиргааны ерөнхий хуулийн суурь зарчим. Аливаа доод шатын байгууллагын гаргасан шийдвэрийг өөрөө юм уу, эсвэл дээд шатын байгууллага нь хянадаг. Энэ бол ерөнхий хуулийн суурь зарчим байгаа.

Ц.Даваасүрэн: Тэгээд хүчингүй болгоно гээд байна. Энэ нийцэж байна уу гээд байхад чинь.

Үгүй, одоо манай нэг аймгийн иргэдийн Хурал нэг газар луу нэгдье гэсэн шийдвэр гаргавал одоо тэгээд хэн ч хүчингүй болохгүй юу. 5.

Т.Даваадалай: Г.Ганбаатар гишүүний асуултад нэмээд тодруулга өгье. Засаг дарга нэгдүгээр орлогч Т.Даваадалай.

Тэр 11 дүгээр сард явсан 242 иргэнтэй хийсэн хэлэлцүүлэг дээр яг энэ авто замын татвар нэмж байгаа дээр иргэдээс асуулт гомдол ирсэн байгаа. Г.Ганбаатар гишүүн ээ.

Тийм учраас бид анх 4 дахин анхны материал дээр санал орж байгаад тэгээд тэрийгээ 3 дахин болгож бууруулсан.

Тэгэхээр иргэдийнхээ бид санал, гомдлыг тусгаж хүлээж авсан байгаа.

Г.Ганбаатар гишүүний хэлж байгаа түрүүний тэр нөгөө иргэддээ мессежээр мэдээлэл өгдөг маш зөв асуудал юм байна. Бид гол чухал асуудлуудтай юмыг дандаа онцгой байдал шиг ч юм уу мессежээр иргэдэд заавал очдог ч юм уу, тэр байдал руу явъя гэж бодож байна.

Мэдээллийн хувьд Г.Ганбаатар гишүүн www.ulaanbaatar.mn болон “Улаанбаатар мэдээ” гэдэг фэйсбүүкийн сошиал платформуудаар бид нарт өдөрт доор хаяж 2-оос 7 удаа Улаанбаатар хотод хэрэгжиж байгаа бүх төсөл, арга хэмжээ, үйл ажиллагааг маш идэвхтэй мэдээлж байгаа.

Сая бас Үндэсний телевиз... /минут дуусав/

Ц.Даваасүрэн: Б.Чойжилсүрэн гишүүн асуултаа асууя.

Б.Чойжилсүрэн: Нэг асуулт хоёр санал байна.

Улаанбаатар хотын өмнө тулгамдсан хоёр асуудал бий.

- Түгжрэл,
- Утаа.

Түгжрэлийг шийдэх гээд янз янзын ажлууд хийгээд л сүүлийн 35 жил явсан байх. Тэрний өмнө ч гэсэн ялгаагүй. Улаанбаатар хот үүссэн цагаасаа л ийм асуудал бий.

Улаанбаатар хот хэд өнөөдрийн байдлаар 800 мянга орчим автомашин бүртгэлтэй байгаа гэсэн тооцоолол сая ярьж байна.

Нэн ялангуяа ковидын дараах он жилүүд 2023, 2024 онууд дээр энэ тоо огцом нэмэгдсэн байх ёстой. Яагаад гэвэл импортоор орж ирсэн автомашины тоо огцом нэмэгдсэн. 2 дахин 3 дахин нэмэгдсэн.

Яг энэ тооцооллоор явах юм бол хэдэн он гэхэд энэ Улаанбаатар хот маань яг тэг зогсолт хийх юм бэ? Зам дээрээ бүх машин нь гарч зогсоод хөдөлгөөнгүй болох.

Улаанбаатар хотын автомашины өсөлтийн таазыг нэг хэлж өгөөч ээ. Олон нийтэд бас үнэнээ хэлэхгүй, та нар энэ зовлонг ойлгуулахгүй бол ингээд л янз бүрийн байдал, шүүмжлэл дагуулаад л яваад байна.

Тэгэхээр Байнгын хорооны тогтоол гарах гэж байна шүү дээ. Иргэд хоёрдугаар заалтад. Иргэдэд тайлбарлан таниулах гэдэг. Энэ дээрээ бүр яг энэ байгаа хүндрэлүүдээ бүгдийг нь яримаар байна.

Түүнээс гадна манай Улаанбаатар хот чинь бараг 5, 6 сарын өвөлтэй. Намрын хөлдөлт, хаврын гэсэлт дээр бол ер нь дийлэнх нь хүчтэй хуваалттай хөрстэй байгаа. Ердийн хөрснөөс хүчтэй хуваалттай хөрсөн дээр барьж байгаа замын өртөг бараг 2 дахин нэмэгдэнэ. Нэмэгтгэнэ, хүчитгэнэ, зузаатгана гээд.

Энэ юмнуудаа бүр сайн яриад, олон нийтдээ яах юм бэ одоо. Үүнийг бид ийм шийдвэр гаргасан чинь ингээд шүүмжлэл дагуулаад байна, хүнд байна. Ард түмэн минь шийдэж өгөөч гэдэг нэг санал асуулга яваад, муу нуухаар сайн илчлээд. Бүр сайн. Иргэдийг бүр мэдээлэлжүүлээд. Ийм санал, асуулт хоёр давхцаж байгаа юм.

Үүнээс гадна Улсын Их Хурлын гишүүддээ нэг зүйлийг Төсвийн байнгын хороон дээр байгаа юм чинь ярьж байна.

Бид сүүлийн 2023, 2024 онд нийлээд 31 тэрбум долларын экспортын орлоготой байсан ийм жилүүд байлаа.

Тэгээд одоо сая манай Л.Оюун-Эрдэнийн Засгийн газар огцорч байгаа юм. Бид бодит байдлыг олон нийтэд ойлгуулж чадаагүй, хүлээлтийг хэт өндөр тавьсан. Үүнээс шалтгаалж олон нийтийн санаа бодол сайнгүй байгаа нь ч үнэн.

Тэгэхээр одоо энэ тансаг хэрэглээний татварыг нэмэх юм уу, нэмэхгүй юм уу. Одоо саяын импорт. Автомашин гэдэг чинь валютаар худалдаж ирнэ. Сэлбэгийг нь валютаар худалдаж авна. Бензин, шатахууныг нь валютаар худалдаж авна. Ингээд зовж зовж жоохон мөнгө олоод, түүнийгээ ямар ч бодлогогүй, ямар ч тооцоогүй бид гадагшаа гаргаж өгөөд байнгын сүүлийн 30 жил төлбөрийн тэнцлийн дарамт, Засгийн газрын гадаад валютын нөөцийн дарамт дээр явсан.

Үүнээс шалтгаалаад ямар ч тийм дунд хугацаанд амьдралаа төлөвлөх бололцоогүй ийм нийгэм.

Ц.Даваасүрэн: 1 минут сунгая.

Б.Чойжилсүрэн: Энэ дээрээ бид олон нийтэд яг үнэнээ хэлээд, Их Хурал нь ч тэр, Засгийн газар нь ч тэр, нийслэлийн удирдлага нь ч тэр нэг шийдвэр гаргуулж авахгүй бол ингээд л тойроод л яваад байгаа юм. Тойроод л яваад байгаа юм.

Хэзээ очиж хад мөргөж унахад их ойрхон болсон. Энэ дээр гишүүд минь бодож үзээч ээ. Энэ дээр улс төржих сэдэв биш байх. Өнөөдөртөө магадгүй Монгол Ардын нам засаглаж байгаа байх.

Ер нь цаашаа энэ бүх намуудын л зовлон байгаа. Энэ дээр улс төржихгүйгээр Төсвийн байнгын хороо Ц.Даваасүрэн дарга аа, шаардлагатай бол энэ төлбөрийн тэнцлийн хэрэглээгээ санхүүжүүлдэг, нэмүү өртгөө

санхүүжүүлдэггүй энэ нөхцөл байдлыг бид засаж чадах юм уу, үгүй юм уу гэдгээ нэг яривал яасан юм бэ? Энэ гишүүддээ тавьж байгаа санал шүү.

Ц.Даваасүрэн: Санал. Тэгээд яах вэ, машины тоо асуусан. Тийм үү?

Ийм юм байна лээ шүү. 2023 онд би Японоос орж ирж байгаа машины импортыг харахад 500 гаруй сая доллар байсан байхгүй юу. Сая би 2 сарын өмнө харахад байна шүү дээ. Тийм ээ. Тэрбум рүү дөхсөн байгаа байхгүй юу. Тэрбум рүү дөхсөн байгаа.

Одоо энэ нөгөө импортолж байгаа машины хэмжээ шүү дээ. Бараг 2 дахин өссөн байна шүү дээ. 2-хон жилийн дотор. 2 жил ч хүрэхгүй байна.

Нөгөө талаараа бидний хүн амын хэрэглэж байгаа хүнс, хоолны импорт 800, 900 сая доллар л байхгүй юу. Гэтэл машины чинь ууж идэж байгаа түлш 2 тэрбум доллар болсон байна шүү дээ. 2 тэрбум доллар. Валютын нөөц 4 тэрбум, 5 тэрбум. Талыг нь хаашаа алдаж байна вэ. Нөгөө машиныхаа хүнсэнд. Машин нь хүнээсээ их иддэг улс хаана байна. Ганцхан Монгол байна.

Тэгэхээр энэ чинь өөрөө юуг хэлж байна гэвэл бид ард түмэндээ хайр зарлаж байна гэж нөгөө төрийнхөө зохицуулах ажлыг хийхгүй байсаар байгаад нөгөө зам гүүрээсээ хэтэрсэн ачаалалтай ийм машиныг бий болгосонг сая хэлээд байгаа юм.

Тэгэхээр машины тоо хэдээс хэд болж байна. Сүүлийн 3 жилээр хэлээдэх. 3 номер уу? Хэн хариулах юм? 3 номер.

Б.Одбаяр: Гишүүний асуултад хариулъя.

Тэгэхээр түгжрэл үүсэж байгаа нөхцөл байдал машины импортолт хэт ихсэж байгаатай холбоотой. Өнөөдөр гэхэд 70-аас 80 мянган машин импортоор орж ирж байгаа. Ерөөсөө жилдээ. 70-аас 80 мянган машинаар нэмэгдээд яваад байгаа.

Гэтэл одоо яг Замын хөдөлгөөн, удирдлагын төв дээр SIMULATION хийгээд үзэж байгаа юм. Тэг зогсолт болоход ойролцоогоор хэдэн машин зам дээр яг зэрэг гарч байна.

ЖАЙКА-ийн хийсэн судалгаа, Дэлхийн банкт хамтраад бүгд 2022 онд судалгааны ажлуудаар ажилласан. Тэгэхэд яг өнөөдрийн байдлаар Улаанбаатар хотын авто зам дээр 420-иос 450 мянган машин гарч ирэхэд хот тэр чигээрээ зогсоно. Тэг зогсолт гэдэг маань HYBRID CONGESTION буюу 0-ээс 5 километр цаг руу хурдтай ороход энэ “тэг зогсолт” гэдэг үнэлгээ рүү орж байгаа юм.

Тэгэхээр 450 мянган машин дээрээсээ гараад нам зогсоод байдаг. Гэтэл 2012 оноос дугаарын хязгаарлалт гараад эхэлж байгаа. Гэтэл бид дугаарын олголт дээр хязгаарлалт тавиагүй учраас COBRA EFFECT гэдэг шиг машины тоо эрс ихэссэн.

Тэгээд нийтийн тээврийн хэрэглээ маань 20 хувьдаа хүртэл буурсан. Өнөөдөр 2020 оныг 2012-2020 оны байдлаар харьцуулаад үзэхэд нийтийн тээврийн хэрэглээ 18 хувьтай болсон байгаа. Нийт иргэдийн зорчилтын.

Тэгэхээр үлдсэн 82 хувь нь авто тээврийн хэрэгслээрээ яваад байна. Гэтэл бидний барьж байгаа бодлого автобусанд яг үнэнийг хэлэхэд 500 төгрөг төлөөд, мянган төгрөг төлөөд явж байгаа хүний сарын хэрэглээ приус машин аваад унасан хүний сарын хэрэглээ хоёр гэх юм бол автобусанд суусан хүн нь илүү мөнгө төлөөд байгаа байхгүй юу. Машинтай хүн нь хямдхан зардлаар яваад байгаа байхгүй юу. Нийтийн тээвэр хэрэглэгчээс.

Тэгэхээр хэн машинаа болиод би нийтийн тээврээ сонгоё гэдэг юм руу явах юм бэ. Байгаа мөнгөн дээрээ иргэний үнэмлэхээ тавиад л ломбардаас очоод л аваад л, банк бусаас аваад л машин зээлээр авчихна. Тэгээд хэдэн сар таксид явж байгаад төлчихнө. Тэгээд явлаа. Сарын, жилийн 20 мянган төгрөг. Жилийн 20 мянган төгрөг төлөөд өнөөдөр.

Харин тэгээд яачхав. Тэгээд одоо ингээд яваад үзэхгүй юу.

Тэгэхээр чинь асуудал үнэхээр байгаа байхгүй юу.

Ц.Даваасүрэн: Бас тэгж болохгүй шүү. Энд Их Хурлын гишүүдийн. Одоо бас хуулийн хүрээнд асуулт ярьж байхад загнаад суугаад байж болохгүй шүү дээ. Нийслэлийнхэн. Ёс зүйн хувьд наадахыг чинь уучлалт гуйх хэрэгтэй шүү.

Б.Одбаяр: Ёстой уучлаарай. Ихэд эмоцилчихлоо.

Ц.Даваасүрэн: Болохгүй шүү. Та нар.

Ингээд гишүүд асуулт асууж дууслаа. Үг хэлэх гишүүдийн нэрсийг авъя.

Ж.Баясгалан гишүүнээр тасалъя. Ажлын хэсгийн дарга үг хэлэх юм уу? Аан. Ажлын хэсгийн дарга дүгнээд л хэлэхгүй дээ. Т.Аубакир гишүүн.

Т.Аубакир: Манай гишүүд орж ирсэн асуудлыг маш сайн ойлгож байгаа.

Мэдээжийн хэрэг татвар нэмэхэд бухимдал дээр бухимдал болсон юм шиг байдал үүссэн. Бид Улсын Их Хурал, Байнгын хороо үүнийг нь аваад хэлэлцье гэхээр бид нутгийн өөрөө удирдах ёсны эрхэд халдсан, Үндсэн хуулийн зөрчил болно.

Одоо яг эндээс бид нарын гаргах шийдвэр бол их тийм, бид шийдвэр гаргах юм бол шууд Үндсэн хуулиа зөрччихнө. Одоо иргэдийн хурал руу шууд үүрэг чиглэл өгөөд, наад татвараа буулга гэж хэлэх эрх байхгүй байгаа байхгүй юу даа. Буулга гэж хэлэх эрх байхгүй.

Татвар нэмсэн нь алдаатай, эсвэл процессын алдаатай байна гэж үзвэл Захиргааны хэргийн шүүхэд хандаж болж байгаа юм. Одоо иргэн. Тийм ээ. Захиргааны хэргийн шүүхэд хандана.

Нэг бол Үндсэн хуулийн зөрчилтэй байна. Бид нарын таатай орчинд амьдрах, эрүүл амьдрах, янз бүрийн хүний эрхийг зөрчсөн байна гэж үзэж байгаа бол иргэн маань Үндсэн хуулийн цэцэд хандаж болно. Захиргааны шүүхэд хандаж болно. Хэрвээ энэ процесс нь алдаатай байна гэж үзвэл тэр иргэн маань. Бид биш. Гомдол гаргасан иргэн маань захиргааны процессын алдаатай байна гэж үзвэл. Тийм ээ.

Ийм л хоёр гаргалгаа байгаа юм.

Одоо янз бүрийн статистикууд хэлж байна л даа. Манай нийслэлийнхэн маань үнэхээрийн 10 жилийн өмнөхтэй харьцуулах юм бол замын урт нь хоёр дахин нэмэгдсэн. Автомашины тоо нь хоёр дахин нэмэгдсэн.

Түрүүн нийслэлийнхэн хэлж байна. Үнэтэй машин унаад явж байгаа хүмүүс нь илүү татвар төлөх юм гэж. Тийм ээ. Тэгж л байгаа шүү дээ.

Бусад энгийн хэрэглээний машин унах юм бол бас татвар нь тухайн хөдөлмөрийн хөлснийхөө доод хэмжээтэйгээ уялдсан, одоо тэр машиныхаа үнэтэй нь уялдсан, хэрэглээнд нь уялдсан байдлаар эднийх нь юугаа тогтоож өгөөд байна шүү дээ. Татвараа.

Хэрвээ татварын асуудал ярих юм бол. Процесс яривал бид Нийслэлийн иргэдийн Хурал руу ярих ямар ч боломж байхгүй.

Нэгэнт л энэ хуулийг үндэслээд танайхан татвараа нэмсэн шүү дээ. Монгол Улсын авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийг үндэслээд Их Хурлаас батлаад өгсөн хуулийн хүрээнд Та нар татвараа нэмсэн байхгүй юу даа.

Энэ дээр мэдээжийн хэрэг үзэгчид маань бас байгаа, ард иргэд маань бас буруу ойлгочих вий. Энэ бол зөвхөн нийслэлд явж байгаа авто тээврийн хэрэгслийн татварын л асуудал бид ярьж байгаа. Хөдөө орон нутагт байдаг ч юм уу, аймгуудаар явж байгаа автомашины татварын асуудал энд огт хамаагүй.

Тийм учраас энэ бол зөвхөн нийслэлийн авто тээврийн татварын асуудал яригдаж байгаа. Бид хүн болгон л гараад л хэлдэг хамгийн эхний асуудал түгжрэл гэдэг. Зам чинь нарийхан байна. Зам чинь муу байна. Зам маань даац

нь хэтэрсэн байна гэдэг. Одоо үүнээс хураасан хэдэн төгрөгөөрөө энэ замаа л арчилж байгаа шүү дээ.

Хамгийн гол нь манай нийслэлийнхэн авто тээврийн татвараа аваад зөвхөн тэр авто тээврийнхээ тэр замынхаа ашиглалт байдаг ч юм уу, түгжрээндээ л зориулах хэрэгтэй.

Тийм учраас гишүүд маань одоо бид эндээс нэг гаргалгаа заавал гаргах ёстой. Яагаад гэвэл иргэн Улсын Их Хуралд хандсан. Их Хурлын бүтэц, байгууллага Байнгын хороо үүнийг нь авч хэлэлцэх хуультай учраас бид эндээс ямар нэгэн байдлаар Засгийн газар луу чиглэл өгдөг юм уу. Үгүй бол дахиад нэг ажлын хэсэг байгуулагдаад яг одоо эд нар маань энэ хуулийг батлахдаа процессын алдаа гаргасан юм уу, үгүй юу гэдэгт нь хяналт тавих ажлын хэсэг гаргах ийм л хоёр зам бий. Ажлын хэсэг дээр ажиллаад.

Хууль тогтоох эрхээ аваагүй. Дарга аа, татвар тогтоох эрхээ л авсан.

Биш ээ, дарга аа, эд нар чинь хууль тогтоогоогүй шүү дээ. Татвараа л тогтоогоод байгаа юм л даа.

Ц.Даваасүрэн: Х.Ганхуяг гишүүн.

Х.Ганхуяг: Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын дээд шатны байгууллага ер нь Их Хурал гэж ойлгоод байх шиг байна л даа. Их Хурал биш юм. Одоо жишээлбэл нийслэлийн иргэдийн Хурлын дээд шатны байгууллага гэдэг маань Улаанбаатар хотын иргэд гэсэн үг. Ер нь бол. Зүгээр маш ойлгомжтой байдлаар.

Тэгээд энэ нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын бие даасан байна гээд Үндсэн хуульд угаасаа заасан байгаа.

Тэгэхээр энэ асуудал өөрөө Үндсэн хуулийн асуудал болох юм. Үндсэн хуулийн асуудал болно гэсэн үг. Хэрэвзээ энэ болохгүй байна гэх юм бол Үндсэн хуульд л хандах эрхтэй гэсэн үг. Иргэд. Тийм. Цэцийн асуудал гэсэн үг.

Хоёрт болохоор тогтоочхоод байгаа татвар маань өөрөө эргээгээд 33 мянган иргэн буюу асар олон иргэн энэ дээр гомдолтой байгаад байна гэдэг маань өөрөө 33 мянган автомашин эзэмшигчийн л асуудал байгаа байхгүй юу.

Бид өнөөдөр хэрэглээнийхээ татвараараа л төсвийн орлогыг нэмэгдүүлэх, яг тэр хэрэглээтэй нь уялдуулж авто замаа барьдаг байх, засдаг байхгүй бол 20 тэрбум төгрөг гэдэг маань үндсэндээ 8 километр замын л мөнгө шүү дээ. Ер нь бол.

Тэгэхээр чинь бид цаг хугацаандаа замаа засахгүй. Тэгээд нөгөө машин унадаг иргэд маань өөрсдөө замаа засахыг шаарддаг, шинээр зам тавихыг шаарддаг. Тэгээд 20 тэрбум бол угаасаа хаанаа ч хүрэхгүй. Ерөөсөө л ингэж.

Тэр 130 тэрбумаар харин ямар ямар зам хаана тавьсан юм, яаж зассан юм гэдэг асуудлыг л бид мэдээллээ авч иргэдэд мэдээлэх үүрэгтэй болохоос биш. Түүнээс биш нөгөө автобусаар зорчиж байгаа, дугуй унаж байгаа иргэдээс авч байгаа тэр НӨАТ байдаг юм уу, хүн амын орлогын албан татвар байдаг юм уу, эд нараас бүрдэж байгаа мөнгөөр эргээгээд зам тавина гэдэг маань өөрөө утгагүй асуудал байгаа.

Ингэж байж бид хэрэглээг нь хязгаарлах тал руугаа бид татварын бодлогоо зөв болгож явахгүй бол нөгөө болохгүй байгаа. Ийм юмнуудыг хязгаарлаад эхлэхээр эргээд бусад татваруудаа бууруулах боломжгүй болчихдог байхгүй юу.

Тэндээс орж ирж байгаа мөнгийг нь ингээд авто зам руу тавина. Тэр нөгөө хүн амын орлогын албан татвараас орж ирж байгаа мөнгийг нь явган хүний зам тавина. Ингээд явахаар эргээгээд нөгөө хүн амын орлогын албан татвараа бууруулж болдоггүй. Нөгөө НӨАТ-аа бууруулж болдоггүй. Нөгөө аж ахуйн нэгжийн орлогын албан татварыг бууруулж болохгүй. Үндсэн шалтгаан нь ийм шүү.

Бид аль нэг салбар дээр хөнгөлөлт өгөөд л, аль нэг салбар дээр урамшуулал өгөөд л эхлэхээр угаасаа татвараа бууруулах боломжгүй болчихоод л байдаг юм. Баярлалаа. Дарга.

Ц.Даваасүрэн: Б.Түвшин гишүүн үг хэлье.

Б.Түвшин: Энэ зам ашиглалтын төлбөр нэмэгдсэн.

Улаанбаатар хотод тээврийн хэрэгслийн татвар нэмэгдсэнтэй холбогдуулаад бас төсвийн тухай асуудал ч яригдаж л байх шиг байна.

Зүгээр ер нь бол энэ хэрэглээ хянах, хасах гэдэг бол хамгийн сүүлийн л шат шүү дээ. Сүүлийн 5 жилд манай Монгол Улсын төсөв 2.4 дахин нэмэгдсэн. Өнөөдөр бид боловсруулаад гаргаж байгаа, нэмүү өртөг үйлдвэрлээд гаргаж орлого олж чадахгүй байгаа. Нийслэлийн маань төсөв 33-аас 46 хувь сүүлийн 2 жилд нэмэгдсэн.

Тэгээд зам тээврийн болон ашиглалтын зардлууд 3-аас 4 дахин нэмэгдэж байдаг.

Ер нь том зургаар нь харах юм бол манай Монгол Улсын төсвийн орлого асар их өсөж байгаа. Эргээд Монгол Улсад үлдэх, эсвэл Монгол Улс өөрөө үр

ашигтай юм хийх иргэдийн ахуй амьдрал дээшлэх юм ерөөсөө л бий болохгүй байгаа юм.

Тэгэхээр бид том зургаараа энэ улсын төсвийг зүгээр шууд л урсгал зардал болгоод л тухайн жилд нь гаргачхаад байгаа юм.

Тэгээд одоо хэдүүлээ буцаагаад иргэдийнхээ хэрэглээг хасах замаар энэ асуудлыг шийдье гэж байгаа бол энэ эдийн засгийн арга биш ээ. Бид энэ татварын, ялангуяа энэ хэрэглээний татварын тайлангуудыг нэг бүрчлэн олон нийтэд ил болгох хэрэгтэй.

Одоо энэ зам ашиглалтын татвараар юу хийсэн юм, НӨАТ-аар юу хийсэн юм. Ялангуяа сүүлийн хэдэн жилүүдэд өсөж байгаа юм шударга, ил тод, нээлттэй байж иргэдийн бухимдал, гомдол тайлана. Тэгэхгүйгээр бид татварыг нь нэмээд үүгээр чинь зам засаж байна гэдэг ийм байдлаар яриад яваад байх юм бол энэ чинь цаашдаа шийдэгдэхгүй.

Одоо манай Монгол Улс чинь өнгөрсөн 2025 онд хамгийн том төсвөө баталсан шүү дээ. Нийслэлийн төсөв 2025 онд бүр 46 хувь өссөн шүү дээ. Тэгээд эргээд бид үр бүтээлтэй, эргээд эдийн засгийн өгөөж өгөх юм хийхгүй учраас тэр төсөв нь урсгал зардалд зарцуулсан зардал болно. Дахиад зардал нэхээд байгаа. Тэгээд үүнийг дандаа татварын аргаар шийднэ гэвэл бас болохгүй ээ.

Ийм учраас бид тэр хэрэглээнд суурилсан татварын зарчмуудыг энэ Төсвийн байнгын хороон дээр цаашдаа ярих ёстой байх.

Үнэхээр хэрэглээнд суурилсан татварын асуудал явж байж татварын нэр төрөл болгоноороо тайлан гаргаж, олон нийтэд тайлагнадаг энэ зарчим дээр суурилж байж, энэ шударга байна уу, ил тод байна уу гэдэг дээр суурилж байж энэ татварын нэмэгдэх асуудлуудыг бид бас ярих ёстой.

Тэгэхгүйгээр энэ татварын зарцуулалт нь өөрөө тод тодорхойгүй, олон нийтээс санал аваагүй, хэрэглээ, зарцуулалт нь үр дүнгүй байгаа тохиолдолд татвар нэмнэ гэдэг бол иргэдийн бухимдлыг төрүүлдэг ийм л зүйл байгаа юм.

Түрүүн бас тэр томоохон хэрэглээнүүдийг таная, машиныг хасъя, элдэв долоон хэрэглээний татвар нэмье гэж байгаа юм.

Монгол Улсад одоо бүх төрлийн татвар дээд хэмжээндээ тулсан шүү. Үүнээс дээш төлөх чадамж иргэд, аж ахуйн нэгжүүдэд байхгүй.

Яг энэ тохиолдолд бид энэ өсөж байгаа төсвөө үр ашигтай болгож хувиргах тэр бодлогоо л хийхгүй бол яг өнөөдрийн энэ байгаа байдлаар урсгал зардлаа ингээд яваад байх юм бол Монгол Улс иргэд нь ядуурч, аж ахуйн нэгжүүд нь татварын дарамтад орж, улс маань өөрөө ингэж баяжиж байгаад

нэгээхэн экспортууд буурахад л бид баахан өр төлбөрт орох ийм эрсдэлтэй болчихоод байгаа юм.

Тийм учраас нийслэлийн иргэдийн Хурлын гаргасан энэ шийдвэрээ өөрсдөө эргэж харах шаардлагатай. Энэ дээр Их Хурал хуулийн дагуу ямар нэгэн дүгнэлт зөвлөмж л өгнө үү гэхээс биш ямар нэгэн шийдвэр гаргах боломжгүй.

Энэ татваруудыг ил тод байлгах, энэ татваруудын нээлттэй байдлыг иргэдээр хэлэлцүүлдэг байх дээр харин Их Хурал, ялангуяа Төсвийн байнгын хороо энэ дээр томоохон бодлогуудыг авч хэрэгжүүлэх шаардлагатай гэж үзэж байна.

Ц.Даваасүрэн: Х.Болормаа гишүүн.

Х.Болормаа: Сайн байцгаана уу? Та бүхэндээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Ер нь дахь Б.Түвшин гишүүний саналтай яг л агаар нэг саналуудыг би бас Та бүхэндээ хэлье гэж бодож байсан юм.

Гэхдээ ямар ч байсан энэ тооцоо судалгаа, тоо хэмжээнүүдийг харахад үнэхээр хангалтгүй байна. Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал 2025 оныхоо төсвийг батлахдаа авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын хувь хэмжээг, мөн авто зам ашигласны төлбөрийн хэмжээг шинэчлэн батлах дотоодын төслийг хамт баталсан байгаа.

Тэгээд түрүүн манай Ж.Баясгалан гишүүн асуусан. Энэ иргэдээс авсан санал асуулга гээд энэ дээр хоёр, гурван хувилбараар хариулт өглөө. Үнэхээр санал асуулга авсан юм уу, үгүй юм уу гэдгийг би лав сүүлдээ яг тодорхой хариултыг авч ойлгоогүй.

Иргэдийн санал гэдэг бол хамгийн чухал санал байдаг. Тэр дундаа нийслэл Улаанбаатар хотод Монгол Улсын нийт хүн амын 50 гаруй хувь нь амьдарч байна.

Тэгээд цахим хэлбэрээр буюу нэг бүдэг бадаг нэг өнцөгт нь тавиад санал асуусан нэртэй явсан мэдээ мэдээллүүд сая яриад байх шиг байна. Нийслэл Улаанбаатар хотын 9 дүүрэгт иргэдийн Нийтийн Хурлын танхим ажилладаг. Яг тэр танхим иргэдийн нийтэд болж байгаа, нийслэл Улаанбаатар хотод болж байгаа мэдээ мэдээлэл, иргэдийн Нийтийн Хурал хурлаа зарлаад мэдээ мэдээллүүдийг авах, тэнд бүх сургалт хурал, зөвлөгөөнийг зохион байгуулах ийм бүрэн эрхтэй.

Тэгэхээр яагаад үүгээр төрийн байгууллагуудаа, иргэдийн нийтийн хурлаа ашиглаж энэ санал асуулга явуулаагүй юм бэ гэдэг асуултыг Та бүхэнд хэлэхийг хүсэж байна.

Дээр нь нэмээд Улаанбаатар хотод нийтдээ 718 мянган тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байж байна. Энэ тоо хэмжээ хоорондоо аягүй их зөрүүтэй байна. Би дүүргийн Засаг даргын орлогч байхаасаа авхуулаад авто тээврийн өөрөө явагч хэрэгслийн албан татвар дээр яг хуваарьт юугаар ажиллаж байсан.

Тэгэхээр энэ тоонууд үнэхээр дандаа хөөсөрсөн тоонууд байдаг. Одоо байгаа 718 авто тээврийн хэрэгслээс өнөөдөр яг хөдөлгөөнд орж байгаа хэчнээн тээврийн хэрэгсэл байна.

Тэр дундаа аж ахуйн нэгж, байгууллагууд буюу гэр хорооллын манай иргэдийн хашаанд, аж ахуйн нэгжийн хашаанд маш олон тээврийн хэрэгсэл бүртгэлтэй, тэгээд сэг болсон хэрэгслүүд байдаг. Энэ тоонд орсон явж байдаг. Үүнийг бид ерөөсөө ялгаж салгаж чаддаггүйгээр энэ хөөсөрсөн тоо яваад байдаг.

Гуравдугаарт, өнөөдөр авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварыг ингэж нэмснээрээ, мөн зам ашигласны төлбөрийг 5 дахин нэмснээрээ, авто тээврийн татварыг 3 дахин нэмснээрээ өнөөдрийн нөхцөл байдал Монгол Улсын ард иргэдийн амьдрал өнөөдөр ямар байгаа билээ.

Би та нарт нэг жишээ хэлье. 2021 онд талхны үнэ 1280 байсан. Өнөөдөр 2025 онд нэг ширхэг талх... /минут дуусав/

Ц.Даваасүрэн: Ж.Баясгалан гишүүн.

Ж.Баясгалан: Ерөөсөө хариултаа тэгээд л бөөрөнхийлсөөр байгаад л. Ер нь эндээс би үнэн хариулт сонсохгүй юм байна л даа.

Улаанбаатар хот гээд түрүүн хэллээ. Пэйж 10 мянган лайктай мөн үү. Тийм ээ. Тийм. 10 мянган лайктай юм байна. Улаанбаатар хот маань 1 сая 700 мянган хүнтэй. Тэгээд тэр 10 мянган хүн хэдэн төрийн албан хаагч, хэд нь яг иргэд байгаа вэ. Тэр яг үнэхээр төлөөлж чадах юм уу.

Үнэхээр нэг бүр ичмээр юм нь Улаанбаатар хот бүхэлдээ санал асуулга асуухад 2-хон хүн санал асуулгад оролцсон хэрнээ жирийн нэг иргэн гарын үсэг цуглуулангуут ерөөсөө 33 мянга болоод л Их Хурал дээр ороод ирж байна шүү дээ.

Тэгэхээр энэ дээр та нар маань бодоорой. Үнэхээр тэр сайтын хандалт нь ямар байдаг юм.

Түрүүн 7 номер хэллээ л дээ. Хуульдаа ийм болохоор бид ингэж байгаа юм. Хуульдаа угаасаа хүний тоо тусгаагүй. Үгүй ээ, тэгээд хуульд хүний тоо тусгаагүй байж болно. Гэхдээ та нарын хийж байгаа ажилдаа хандаж байгаа хандлага нөгөө талдаа тийм биш. Хийсэн болоод л өнгөрч байна. Гэтэл энэ хэдэн хувь байх ёстой юм, хэд рүү дөхүүлэх юмсан, ядаж хэдэн хүний санал илүү оруулах юмсан гэж ажилласан тэр сэтгэл чинь хаана байгаа юм.

2 хүн. Өө ашгүй болсон. Магадгүй нэгнийх нь эхнэр, нэгнийх нь нөхөр ч бичсэн байж болно шүү дээ.

Ингэхээр энэ дээрээ яг иргэдтэйгээ нээлттэй бай. Бид та нарын татвар нэмсэн, хассан тэр дотоод асуудал руу ерөөсөө ороогүй байгаа. Процедурын энд алдаа гарсан юм уу, гараагүй юм уу. Яагаад гэвэл тэр 2-хон хүн гэдэг чинь өөрөө алдаа байгааг л илэрхийлээд байна шүү дээ.

Дахиад хэлье. Улаанбаатар хот, ажиллаж байгаа ажиллагсдын тоо нь хэд вэ. Нийт бүрэлдэхүүн. Тэгэхэд ийм том байгууллага хэвлэл мэдээлэлтэй, сайттай, санал асуухад 2-хон хүний саналаар шийдэж байна гэхэд ганцхан иргэн хувийнхаа фэйсбүүкээр уриалаад л, тэгээд л 33 мянган хүний санал гараад ирж байна.

Тэгэхээр тэр 2 санал иргэдийн дунд явуулсан судалгаа гэж ерөөсөө тооцогдохгүй. Хэлэлцүүлэг дээр түрүүн бас хэлсэн. Хэлэлцүүлэг явуулсан гээд яриад байх юм. Явуулаагүй шүү дээ. Хэлэлцүүлэг чинь дангаараа авто тээврийн татварыг нэмэх асуудлаар яваагүй гэсэн шүү дээ. Төсөв ярьсан. Тэр дунд байсан гэсэн шүү дээ.

Тэгэхээр хэлэлцүүлэг явуулсан гэдэг үгээ бүр авч хая. Ерөөсөө ганц бодитой мэдээ гэвэл иргэдээс авсан санал асуулга авсан. Тэр нь Улаанбаатар хотын сайтаар авсан. 2 хүн хариулсан гэдэг л юм байгаа юм байна.

Ц.Даваасүрэн: Да.Цогтбаатар гишүүн үг хэлье.

Да.Цогтбаатар: Байнгын хорооны гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Хэдхэн хоногийн өмнө Засаг огцруулах асуудал орж ирж байхад Ерөнхийлөгч өөрөө орж ирээд хэлсэн. Хүн биш хууль засагладаг Монгол Улс байна.

Тэнд 5 төлгөн коммунист суучихсан. Одоо энэ хотын гудамжаар хүн загнаад л яваад байдаг нэг саарал хувцастай коммунист дарга шигээ болчхож та нар. Ямар ч иргэдтэйгээ харилцаа байхгүй. Ulaanbaatar.mn гээд л хүн болгон өдөр болгон нэг веб сайт руу дараад ороод та нарт санал өгье гээд сууж байх уу.

Г.Ганбаатар гишүүн эндээс мессеж явуулаад хийдэг аль дэвсгэрийн асуудлыг одоо за ойлголоо, нэг хэрэгжүүлж ажиллахыг бодъё.

Би та нарыг болдог бол нөгөө хүнгүй хот гээд байгаа тэр Хүннү хот, эсвэл тэр Хархорин хот дээр очоод, иргэнгүй юм чинь тэнд очиж ажиллавал та нар таарна.

Та нараас ямар ч тэр иргэдийн машинтай байх эрхийг дээдэлъе, машинтай нь байлгая, эсвэл аз жаргалтай хотод амьдруулъя, түгжрэлгүй амьдруулъя гэж байгаа сэтгэл гарахгүй байна шүү дээ.

Одоо та нар харж байгаарай. Наана чинь 5 дарга сууж байна. 5 машин. Түгжрэл мөн үү, төсвийн зарлага мөн үү, тансаглал мөн үү. Тэгээд хаана байгаа юм. Та нарын тэр төсөв хэмнэнэ гээд байгаа юм.

3 номер дээр сууж байгаа дарга, уучлаарай, танд загнуулах гэж энд орж ирээгүй за юу. Очиж тэр Х.Нямбаатарыгаа загна. Дараад нь Их Хурал руу халдана шүү.

Бүүр одоо тэгээд бүгдээрээ сүүлдээ хэнийг ч хамаагүй загнаж байна гэж битгий андуураад бай л даа. Та нар.

Э.Бат-Үүл дарга чинь нэг гоё цэцэг алагласан хот л өгсөн шүү дээ. Одоо хаана байгаа юм. Бүгдээрээ түгжрэлтэй, бүгдээрээ стресстэй, бүгдээрээ утаандаа хордож үхэж байна шүү дээ.

Нэг гэр бүлийн 6 хүн хордоод үхсэн. Та нараас хэн нь хариуцлага хүлээсэн юм. Бүгдээрээ тэгээд л иргэдээ загнаад сууж байдаг. Ийм хариуцлагагүй байна гэж байгаа юм бол би та нарт дахиад хэлъе. Хүннү, Хархорин гээд тэр хүнгүй хотын дарга бол за юу. Иргэдээсээ ингээд вакумжаад тасарчих юм бол. Тийм ээ.

Өнгөрсөн жил та нарт төсөв байхгүйдээ энд татвар нэмэх гээд байгаа асуудал биш байхгүй юу даа. Дөнгөж саяын жишээ энэ Төв шуудангийн хажуу талд явган хавтан хуулаад бүгдийг нь чулуужуулаад сууж байна шүү дээ. Зөв зүгээр байсан хавтан. Тэгээд та нар татвар нэмж яах гэж байгаа юм. Та нарын тансаглалд мөнгө өгөх албагүй шүү дээ. Иргэд өөрсдөө тансаг амьдарч байж дараад нь та нарт өгнө шүү дээ. Хаана тэр иргэд чинь тансаг амьдраад байгаа юм. Аль болох энэ хотод чинь нэг юм өөрсдийнхөө ажил амьдралыг зохицуулаад амьдрах юмсан гэж бодоод л 2 машинтай нь 2 машинтай, 1 машинтай нь лизингээр авсан нь лизингээрээ аваад л явна шүү дээ.

Яахаараа заавал та нараас зөвшөөрөл авч байж машин лизингээр авч унадаг юм. Ийм аймаар коммунист сэтгэлгээнээсээ сал л даа та нар. Тэгээд ичихгүй 1 сая 700 мянган хүнтэй хотын удирдлагууд гээд солиороод суугаад байх юм.

Тэгээд одоо уг нь та нар бүр эсрэгээрээ энэ дүрэм зөрчөөд байгаа жолооч нартаа ногдох хариуцлага, ур чадвар муутай байгаа жолооч нарын хариуцлага, авто сургуулиуд гээд бүр эсрэгээрээ шийдэл хайх ёстой, инженерийн шийдэл хайх ёстой байтал татвар нэмнэ. Та нарын толгойд өөр юу ч орохгүй байна.

Уг нь энэ чинь сонгуулиар сонгогдоод л баахан гадаад, дотоод төгссөн шилдэг боловсрол эзэмшсэн хүмүүс орж ирлээ гэсэн чинь зүгээр л нэг хэдэн коммунистууд ороод ирсэн. Тэгээд яадаг юм гэсэн юм яриад сууж байх юм. Ичээч та нар.

Өө бүүр одоо сүүлдээ нээрээ. Та нараас нээрээ үнэхээр хүлээх юм алга. 2-хон хүнээс санал авчхаад Улсын Их Хурлын түвшинд хүртэл асуудлуудаа яриад сууж байна шүү дээ. 2-хон хүн. Та нар хэвлэл мэдээлэлтэй гэрээ байгуулахаараа бүгдтэй нь хэвлэлийнхэнтэй хаалтын гэрээ хийсэн. Та нарыг одоо бараг унгахад чинь хүртэл магтаад сууж байгаа шүү дээ.

Яагаад тэр хэвлэл мэдээллийнхэнтэй та нар гэрээгээ байгуулж энэ асуудлуудаа яриулаагүй юм. Бид энэ татвар нэмэх гэж байна. Бүх хэвлэл мэдээллийн байгууллагууд ороод үүнийг ингээд нээлттэй хэлэлцүүлээд өг гэж хэнд нь хэлээгүй юм. Хэн ч хардаггүй нэг муу пэйж рүүгээ хамаг буруугаа чихчхээд наанаа тансаглаад сууж байхыг ичиж амьдрах хэрэгтэй.

Ц.Даваасүрэн: Н.Алтанхуяг гишүүн үг хэлье.

Н.Алтанхуяг: Энэ тогтоолын төсөл ингэж гарах буруу л юм шиг байна. Та нар үүнийгээ дахиад яриач.

Би зүгээр нийслэл дээр хэлэхэд байна шүү дээ, энэ залуучуудад та нарын буруу ч гэж байхгүй байх. Загас толгойноос өтдөг байхгүй юу. Толгой дээр чинь өт байхаар та нар бүгд өт болж байгаа. Толгой дээр чинь дарангуйлагч байхаар бүгдээрээ дарангуйлагч болж хувирч байгаа. Одоо хувирч явах шиг байна бас.

Энэ ерөөсөө яах гэж дарга нар бий болдог юм. Энэ ард иргэдээсээ саналыг нь аваад, ард иргэдийнхээ дэмжлэгийг аваад, тэд нарынхаа боломжийн амьдралын төлөө аж ахуйн нэгжүүдийгээ дэмжье л гэж л би дарга болж байгаа гэж ойлгож байгаа.

Ер нь зовлон байгааг би ойлгодог. Нийслэл дээр ч зовлон байдаг, засаг дээр ч зовлон байдаг. Ажил хийж байгаа хүнд зовлон байдаг. Ингээд юм хумаа нэмье, үнэ өртгөө нэмье, тариф марифыг ингээд.

Та нартай зам засах чинь буруу гэж хэн ч яриагүй. Тэр Эрчим хүчний Б.Чойжилсүрэн гараад явчихлаа. Б.Чойжилсүрэнд би бас хэлж байсан юм. Тэр нь цахилгаан, дулааны үнийг тодорхой хэмжээгээр бас үе шаттай нэмэгдүүлээд явдаг. Энэ бол хийдэг л ажил, болдог л ажил.

Та нар 15 жил нэмээгүй юмыг 3 дахин нэмнэ гэж ямар солиотой галзуутай юм бодож олдог байна аа. Энэ эрүүл хүн үү, өвчтэй хүн үү, хүн мөн үү. Ер нь.

Хүмүүсийн ахуй амьжиргаа хэдэн хувиар өссөн юм. Цалин хөлс нь хэд вэ. Тэтгэвэр 3 дахин өссөн юм уу. Яагаад амьдралгүй ийм юм хийдэг юм бол оо. Энэ бол би иргэдээсээ их салсан, тасарсан. Энэ Ардын нам сүүлийн 10 гаруй жил засаглаж байгаа. Одоо Улаанбаатар хотод 44-өөс билүү, 40 хэд билээ. Суудал. 45-аас 42, 43 нь Ардын нам.

Сонгинохайрхан дүүргийн 43 суудлаас 43 нь Ардын нам. Энэ Ардын нам мундагтаа гараад байна гэж бодоод байгаа юм уу. Ард иргэдийнхээ төлөө юу ч хийхгүй байж яагаад яваад байдаг юм. Энэ бол хулгай дээрэм хийгээд л байгаа, сүлжээ байгуулаад л байгаа. Улсын төсвийн мөнгөөр хэдэн пальдага хүмүүсийг тэжээгээд л байгаа.

Энэ нэг жаахан ийм үнэн юмаа яриад шийдмээр байх юм.

Та нарын наадах чинь буруу байна шүү дээ, залуучууд аа. Та нарыг шүүмжлээд байх хэцүү юм. Хөөш.., М.Үнэнбат чи манай хуулийн зөвлөх байхгүй юу. Манай хууль зүйн. Одоо нийслэлд очиж байна шүү дээ. Чи одоо тэнд очсон чинь бас тэндхийн хүн болжээ чааваас. Одоо боль доо та нар. Залуу хүмүүс нэг жаахан зарчимтай, ард иргэдийнхээ санаа сэтгэлийг сонссон.

Ард иргэдийн санал. 2-хон хүний санал өгнө гэж юу байх вэ дээ, залуучууд аа. Тэгээд тэрийгээ бид 3, 4 цаг ярилаа. Больё оо. Сэтгэл зүрх чинь жаахан нэг зөв баймаар байна. Хүмүүсийн төлөө гэсэн бодол саналтай баймаар байна.

Аав, ээжээ хар л даа. Зөвхөн хавь ойрынхныгоо хараад байх юм. Наана чинь Монголд нэг хэсэгхэн хүн сайхан амьдарч байгаа. Амьдралаас тасарчихсан. Ард түмний амьдрал үнэхээр муудсан.

Тэгээд л 14 мега төсөл ярина. Галзуу галзуу том том тоо ярина. Тэдэн тэрбумаар тэгчихвэл ингэнэ. Тийм. Мөнгөөр тэгж ажил явдаггүй юм. Эхлээд сэтгэл зүрх байх хэрэгтэй.

Ялангуяа олон түмнийхээ төлөө гэсэн сэтгэл зүрхтэй байж энэ жоохон мөнгөөр үүнийг нь хийхийн оронд тэрийг нь хийчихвэл олон хүнд хүрэх юм байна гэж ингэж л бодлого гардаг юм л даа.

Би тэгээд сүүлийн үед үнэхээр жоохон санаа зовоод байгаа юм. Арай ч дээ. Хүмүүсийн амьдралыг харахгүй байгаа юм уу та нар. Тэгээд л юм болохоор л татвараа нэмчихье, тэрнийгээ ингэчихье. Үгүй. Ийм их мөнгөөр. Одоо ийм их мөнгөөр диваажин байгуулдаг бол байгуулахаар боллоо. Тэгээд сэтгэл зүрх дутаж байна. Би та нарт хэлье.

Дээр нь та нар ард иргэдтэйгээ зөв харьц л даа. 2 хүний санал авчхаад тэгээд үнэ нэмээд. Нэмэх нэмэхдээ солиотой галзуутай 3 дахин нэмдэг ийм юм дахиж битгий хийгээрэй. Залуучууд аа. Сэтгэл зүрхтэй бай. Мөнгөндөө биш.

Ц.Даваасүрэн: Г.Ганбаатар гишүүн.

Г.Ганбаатар: Би түрүүнд яах вэ ерөнхийдөө бараг саналаа хэлсэн шүү дээ.

12 жилийн өмнө Дорноговь аймагт хийж байсан тэр иргэдийн оролцооны хэлтэс буюу иргэн бүрд гар утсаар нь мэдээлэл хүргэдэг тэр системийг ашигла.

Би одоо тэр бусад гишүүдийн яриад байгаа шиг 2-хон хүнээс санал авсан гэхгүй. Та нарын хэлснээр чинь 240 дээр нэмэх нь 147, тэр хавар намрын чинь ингээд 387 болж байна л даа. Эрх ашиг нь хөндөгдөж байгаа тэр 800 гаруй мянган автомашинтай хүний чинь 0.003 хувь байна шүү дээ.

Тэгэхээр яаж шийдвэр гаргалт чинь ийм байх вэ. Тэгээд өнөөдөр 33 мянган хүн гарын үсэг зурагдаад ирж байна.

Нэг зүйлийг бодоорой, манай нийслэлийнхэн. Та нарын өнөөдөр зарцуулж байгаа төсөв 2013 онд миний хажууд сууж байгаа Н.Алтанхуяг даргын удирдаж байсан Засгийн газрын Монгол Улсын төсөв шүү. 12 жилийн өмнө Монгол Улсын төсөв өнөөдрийн нийслэлийн төсөв байгаа шүү. Ийм их мөнгөөр та нар юу хийж байна вэ гэдгээ бодоорой.

Нөгөө талдаа саяхан бид эрчим хүчний өмнө болохоо байлаа, өртгөөсөө юу яасан гээд эрчим хүчнийхээ үнэ нэмсэн. Үр дүн нь ямар байна. Одоо та нар энэ зам харгуй болохоо байлаа. Дэмжиж байгаа. Тэр юуг чинь. Гэхдээ энэ үнийг чинь аливаа юмны чинь 3-аас 5 дахин огцом нэмж байгааг чинь ерөөсөө дэмжихгүй байгаа шүү.

Юманд жоохон бодитой, судалгаатай хандаж бай л даа. Иргэд ч тэр, аж ахуйн нэгжүүд ч тэр үнэхээрийн туйлдаж байгаа шүү дээ.

Ер нь энэ улс орон, нийслэл ч тэр энэ зээл авах, татвар нэмэхээ зогсоохгүй бол иргэд чинь энэ намар босно шүү. Өнөөдөр та нар ингээд л энд өөдөөс хараад инээд алдаад сууцгааж байж магадгүй. Ямар хүнд болоод байгааг та нар ерөөсөө өдөр тутамд мэдэж байх ёстой шүү дээ.

Би 5 өдөр энд хуралдаад 2 өдөр нь хөдөө Дорноговь, Өмнөговь, Дундговь, Дундговь руу давхиж байгаа байхгүй юу. Тийм учраас их сайн мэдээд байгаа юм.

Тэгээд яах вэ, Улсын Их Хурлаас энэ Улаанбаатар хотын тээврийн хэрэгсэлд ноогдуулж байгаа албан татварынхаа дээд, доод хязгаарыг бас эргэж харах болсон юм байна. Та нарт хуулиар олгосон эрх мэдлээ эргэж харахгүй бол та нар тэр хуулийнх нь интервалыг дээд хэмжээнд нь тултал ашиглаад байна шүү дээ.

Эргэж ер нь нийслэл дээр Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хууль, бусад хуулиудыг эргэж харахгүй бол энэ хуулийн боломжийг та нар тултал ашигладаг улсууд байна.

Ашиглах ашиглахдаа дээд интервалд нь тултал ашиглаад байхад чинь дургүй хүрээд байгаа байхгүй юу.

Эцэст нь хэлье. Ил тод байдал гэдэг чинь иргэдийн чинь мэдэх эрх байхгүй юу. Нийслэлийнхээ. Та нар мэдэх эрхийг нь хангасангүй. Юун нийт эрх ашиг нь хөндөгдөж байгаа хүмүүсийн 0.003 хувь бэ. Иргэдийн оролцоо гэдэг чинь та нарын шийдвэр амьдралд хэр ойрхон бодитой болох вэ гэдэг асуудал байгаа юм.

Тийм учраас үргэлж ил тод байдал, иргэдийн оролцоо гэдэг юмыг нийслэл ч тэр, бусад аймаг, дүүрэг ч тэр хангаж ажиллах ёстой юм. Хэрвээ бид ардчилсан нийгэмд амьдарч байгаа бол. Өнөөдөр тэр байдлын эрхийг нь хангаагүй учраас өнөөдөр Улсын Их Хурал дээр 33 мянган гарын үсэг цуглаж ирчхээд Төсвийн байнгын хороон дээр бид ийм юм яриад сууж байгаа нь харамсалтай байгаа байхгүй юу. Энэ бүгдийг бодож ажиллаарай гэж хэлье.

Ц.Даваасүрэн: Г.Дамдинням гишүүн үг хэлье.

Г.Дамдинням: Гишүүддээ энэ өдрийн мэнд хүргэе.

Түрүүн Н.Алтанхуяг гишүүн хэллээ дээ. Ер нь манай энэ нийслэлийнхэн их л бяртай байна даа. Та нар. Энэ чинь бас нэг төрийн эрх барих дээд байгууллагын төлөөлөл, газар шүү дээ.

Та нар энд ингэж даналзаж байгаа ард иргэдийг дуусгаж байгаа шүү дээ. Загнахгүйгээр ажил хийж болдог шүү дээ. Уг нь. Загнаад дарамтлаад л бүх юмыг хийгээд болоод байдаг гэж харагдаад байгаа бол бас болохгүй л дээ. Стресстэй байгаа байх, ачаалалтай байгаа байх. Дийлэхгүй байгаа бол больчих хэрэгтэй. Дийлээд байгаа бол даналзаад байхаа больцгоо.

Та нарыг төрд үйлчил гэж томилж байгаа болохоос таарсан болгоно загнаад бай гэж сонгоогүй гэдгийг нэгдүгээрт, хэлье.

Хоёрдугаарт, манай ажлын хэсгийнхэн сайн ажилласан байна. Зүгээр энэ би энэ Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоол дээр хоёр, гурван асуудал хэлмээр байгаа юм.

Нэгдүгээрт, бид яах вэ, татвар хураамжийн энэ санхүүгийн аргаар нь боомилох ч гэдэг юм уу, хязгаарлах ч гэдэг юм уу арга хэмжээ авах нь гарцаагүй гэж үзээд байгаа бол нөгөө талд нь хувилбар нь юу юм. Ямар ч гарцгүй юмаар аваачаад татвар хураамжийг чинь нэмнэ гэж шахахаасаа гадна, тэгвэл одоо энэ ард иргэдээ зорчиход нь өөр юу хэрэглэвэл хөнгөлөлттэй байх юм. Өөр хаагуур явбал болох юм. Нийтийн тээврийнх нь үйлчилгээг тэгж сайжруулмаар байна. Гадуур хаа сайгүй хаясан байгаа мопедуудыг ингэж зохицуулмаар байна. Хийж байгаа тэр үнэтэй тэр мундаг сайхан чулуун бордюрууд чинь яаж хийгдсэн байгааг та нар хардаг уу. Тэр Тафа гээд Жет гээд мопедууд байгаа. Би байнга унадаг юм. Та нар унаад яваад үзээрэй. Тэр чулуун бордюрууд чинь тэр мопедууд бүдрээд годройтоод унаад үхчих хэмжээний ийм өндөр өндөр босготой. Стандарт байхгүй. Тэр замын залгаануудыг нь хараарай. Та нар өөрсдөө гараад хар. Өөрсдөө тэр мопед унаад яв л даа. Та нар. Үзээч. Энэ хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг явуулаад, өөрсдөө тэр тэргэн дээр нь суугаад хар л даа. Үзээч. Хүн явах аргагүй шүү дээ. Наадах чинь. Мопед битгий хэл, хөгжлийн бэрхшээлтэй иргэн битгий хэл зүгээр энгийн эрүүл саруул хүн алхаад явахад бүдрээд унахаар юмнууд л хийсэн байгаа шүү дээ.

Тэгэхээр энэ болно гэж байна шүү дээ. Окэй. Та нар хамаагүй ингээд ингээд татвар хураамж нэмээд хиймээр байна. Арга нь энэ байна. Тэгвэл нөгөө талд нь татвараа төлөөд орж ирсэн орлогыг нь хааш нь зарцуулах юм бэ. Зарцуулж байгаа ямар стандартаар зарцуулах юм бэ. Үүнийгээ энэ тогтоолд нь бас тусгамаар байгаа байхгүй юу. Бид. Хийгээд өгмөөр байгаа юм.

Орж ирсэн орлогын 50 хувийг явган замыг сайжруулах, эсвэл энэ мопед энэ тэр юманд зарцуулахыг нь зарцуулна гээд. Ийм чиглэлийн тогтоол бид гаргаж өгч сонголттой болгомоор байна шүү дээ. Алтернатив гаргаж өгмөөр байна шүү дээ. Тэгэхгүй зүгээр л мөнгийг нь татварыг нь нэмж авна гэх юм бол хүмүүс уурлана шүү дээ. Уурлана шүү дээ. Зөвхөн зам засна гээд.

Зам л нэмээд засаад байвал машин нэмэгдээд л байна. Өөр гарцгүй. Бид чөлөөт ардчилсан тогтолцоонд ажиллаж, амьдарч байгаа хүмүүс. Эрх чөлөөтэй хүн юугаа худалдаж авах нь тэр ард иргэдийн асуудал байхгүй юу. Ард иргэдийн асуудал.

Тэгэхээр өөр сонголтыг хэдүүлээ гаргаж өгөх тал дээр нь энэ тогтоол дээрээ бас юмнууд тусгамаар байна. Дахиад энэ дээрээ ярилцъя гэсэн ийм л саналтай байна. Тийм. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Тэгэхээр өнөөдрийн одоо энэ хэлэлцэж байгаа асуудал дээр гол үүсээд байгаа юм Үндсэн хуулиараа нутгийн захиргааны байгууллага, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал татвар тогтоох эрхээ хэрэгжүүлжээ гэж харагдаад байна шүү дээ.

Зүгээр хэрэгжүүлэхдээ процессын алдаа гарсан уу, үгүй юу л гэдэг маргаан яригдаад байгаа байхгүй юу. Тэр иргэдээсээ асуусан юм уу, үгүй юу гээд. Тийм ээ. Үүнийг хэн шийдвэрлэх юм бэ гэж.

Яах вэ, ер нь одоо энэ Үндсэн хуулийн хүрээнд авч үзэх юм бол иргэдийн Төлөөлөгчийн Хурлын гаргасан шийдвэрт хориг тавих эрх Засаг даргад байгаа. Мөн үүнийг хянах эрх нь Засгийн газарт байгаа. Тэр агуулгаар нь Байнгын хорооны тогтоол бэлтгэгдсэн байгаа юм. Тэгэхдээ энэ бол маргаантай асуудал. Би түрүүн гишүүдэд хэлээд байгаа нь тэр. Энэ бол шүүх дээр очих маргаан биш.

Шүүх юу гэж шийддэг вэ гэвэл эрүүгийн хэрэг, эрх зүйн маргааныг. Эрх зүйн маргаан гэдэг чинь хууль хэрэглэх явцад үүсэж байгаа маргааныг хэлээд байгаа байхгүй юу. Хууль хэрэглэх явцад.

Түүнээс биш хууль тогтооход биш. Хууль тогтоох асуудлыг Үндсэн хуулиар оруулсан иргэдийн Төлөөлөгчийн Хурлын эрхийг шүүхээр ярьж эхлэх юм бол энэ ёстой том асуудал болж эхэлнэ.

Үндсэн хуулийн ийм асуудлыг хэн шийддэг вэ гэвэл цэц. Гэхдээ цэцийн олгосон эрх дотор иргэдийн Төлөөлөгчийн Хурлын шийдвэрийг цэц хянана гэж бас байхгүй юм. Их зовлонтой. Тэгээд ингээд хаягдсан байгаа байхгүй юу. Хууль тогтоох эрх байгаад байдаг. Хууль тогтоох эрхийг нь хэн хянах юм бэ гэдэг юм байхгүй. Их Хурлынхыг цэц хянаж байна. Гэтэл иргэдийн Төлөөлөгчийн Хурлын хууль тогтоох эрхээ хэрэгжүүлэхдээ Үндсэн хууль зөрчөөд хэн хянах юм бэ гэдэг юм цэцийн юунд байхгүй болсон байгаа байхгүй юу.

Тэгэхээр энэ их төвөгтэй учраас сая манай ажлын хэсэг энэ тогтоолын төсөл оруулж ирэхдээ Засгийн газарт чиглэл өгөхөөр оруулж ирсэн юм байна лээ.

Тэгэхээр энэ бол одоо бас боломжтой л харагдаж байгаа юм л даа. Миний бодлоор ямар нэг тийм гарц алга. Бид үүнийг цуцлах эрх алга. Цэц рүү хандах юм алга. Тийм ээ.

Уг нь бол яах вэ ингээд хэрвээ энэ цэц рүү хандах асуудал байсан бол Их Хурал цэцэд хандаж болдог. Их Хурлын гишүүн цэцэд хандаж болдог. Гэхдээ энэ нь өөрөө нөгөө цэцийн тэр маргаан үүсгэх 62.2-т байгаа заалтууд дотор байхгүй. Иргэдийн Төлөөлөгчийн Хурлын шийдвэрийг цэц хянана гэж байхгүй байгаа байхгүй юу. Тэгэхээр одоо бид зүгээр чиглэл өгөөд, тэгээд Засгийн газрын хүрээнд.

Эцсийн дүндээ үүнийгээ цуцлах асуудал одоогоор иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өөрт нь байгаа. Өөрт нь байгаа. Тэгэхээр үүнийгээ Та бүхэн нягтлаач ээ.

Зүгээр яах вэ, би ойлгож байна. Түрүүн нэг гишүүн хэлсэн. Мэдээж татварын асуудал яригдахад татвар нэмнэ гэхэд хэн ч дуртай байхгүй. Гэхдээ төр яагаад байгаа юм гэж. Төр зохицуулах гэж байгаа шүү дээ. Татвараа тавихын тулд иргэддээ ойлгуулах ёстой гэдэг дээр танайхыг алдаа гаргалаа гээд байна шүү дээ.

Яг энэ байгаа ирцээрээ явах юм бол машины ачаалал манайд тавигдсан зам, гүүр хэзээ ч гүйцэхгүй. Яагаад ч чадахгүй. Үгүй яах вэ Х.Нямбаатар бол ингээд л гүйгээд л. Зам бол нэлээн тавигдаж байгаа юм билээ.

Тэгэхдээ нэг харамсалтай зүйл байгаа байхгүй юу. Монголд тавигдаж байгаа хоёр эгнээ замын нэг эгнээ нь машины зогсоол болчхож байгаа байхгүй юу. Та нар хараарай. Тэгтэл танайхан, замын цагдаа тэрийг зохицуулахгүй байгаа шүү дээ. Одоо та нар шинэ тавьсан замаа хараарай. Нэг эгнээ нь бүгдээрээ машины зогсоол.

Тэгэхээр үнэндээ зам биш машины зогсоол бариад байгаа байхгүй юу. Та нар өөрсдөө үүнийг эрх зүйн хувьд зохицуулж чадахгүй байна шүү дээ. Их Хуралд оруулж ир.

Тэр нэгдүгээр эгнээнд машинаа тавиад бусдадаа хохирол учруулаад байгаа иргэдийг төр л шийдэхгүй бол чадахгүй. Манай иргэд ухамсраар чадахгүй.

Одоо жишээлбэл би саяхан зам дээр тохиолдож байгаа юмыг хэлье. Энэ Урт цагааны энд. Нэг нөхөр ингээд л хажуудах жолооч нартай хэрэлдээд л яваад байгаа юм. Нэлээн түгжрэлтэй. Тэгснээ өөрөө нэгдүгээр эгнээн дээр машинаа тавьчихаад яваад өгч байгаа байхгүй юу. Тэгээд би цонхоор хөөш чи яагаад тавьж байгаа юм гэхээр юун сүртэй юм гэж байгаа юм. Урдаас. Өөрөө бусдыг тавьж болохгүй гэж хэрэлдэж байснаа аваачаад тавьчихаж байгаа байхгүй юу. Тэгээд өөрт нь хэлэхээр юун сүртэй юм гээд яваад өгч байгаа юм.

Тэгэхээр ухамсраараа манайхан чадахгүй нь ээ гэсэн үг. Манай иргэд. Тэгвэл хэн ойлгуулах ёстой юм. Төр. Энэ замбараагүй хэрэглээг бид улам нэмээд байх юм бол түрүүний хэлдэг тэр тэг зогсолт болно шүү дээ. Нэг өдөр тэгж зогсоно. Иргэд юу гэх вэ. Бид нарыг буруутгана.

Манай Хөвсгөл аймагт болсон одоо бүр амьдрал дээр болсон нэг юмыг хэлье. Бэлтэсбүрэн гээд нэг дээрэм явсан манайд. Мөнгө хүүлдэг дээрэм. Тэгээд би яг эхлэнгүүт нь очиж иргэддээ хэлсэн байхгүй юу. Дэлхий дээр хоёр дахин үржүүлж ашиг өгдөг бизнес хаана ч байдаггүй юм гээд.

Тэгэхээр иргэд надад юу гэж хэлсэн гэхээр “Чи тэжээхгүй байхад эд нар тэжээх гэж байхад чи зайл” гэсэн байхгүй юу. Тэгээд би цагдаад нь очиж хэлсэн. Үгүй ээ, та нар үүнийг зогсоогооч. Энэ аймаар луйвар байна шүү дээ гэхээр хохирол үүсээгүй юм гээд тэнэгтэж байгаа юм.

Ингээд юу болсон. Луйвар төгсгөлдөө хүрсэн. Бүгдийг нь луйвардсан. 50 хэдэн тэрбум төгрөг луйвардсан. Тэгэнгүүт иргэд юу гэж хэлсэн гээч. Үгүй, та нар зогсоож өгөхөд яасан юм гэж.

Эцсийн дүндээ тэгэхээр хариуцлага хэн дээр ногдож байна. Төр дээр. Ойлгохгүй байгаа иргэдийг яах юм. Захиргааны журмаар шийдэхээс өөр арга байхгүй шүү дээ. Тэгэх гэж энэ төр байгаа шүү дээ.

Бид халамж, хайр, хэн нь иргэддээ хайртай вэ гэж уралдсаар байгаад яасан улс орноо сүйтгэж л байгаа байхгүй юу. Энэ 2-оос 3 их наяд халамжийн мөнгө чинь зүгээр бид нарын нүүрсээр, баялгаараа олж ирсэн мөнгийг баас, шээс, хувцас л болгож байгаа шүү дээ. Энэ халамж чинь. Ямар нэг үйлдвэр, баялаг ерөөсөө босохгүй байгаа шүү дээ.

Тэгэхээр өнөөдрийн манай улс төрчдийн ухамсрын доройтол өнөөдөр манай нийгмийг ийм болгосон байхгүй юу. Тэгэхдээ та нар тэглээ гээд Их Хурлыг ирээд загнаж болохгүй. Энэ чинь ард түмнээс сонгогдсон төлөөлөл. Чи өнөөдөр энд суухдаа сонгогчийнхоо үүднээс суугаагүй байхгүй юу. Чи төрийн албан хаагч, энд ажлаас шийдүүлэх гэж орж ирж байгаа хүн шүү дээ чи. Үгүй, би үг хэлэх бас эрхтэй. 3 минутын эрхтэй.

Тийм учраас та хэд ажлаа хийхийн тулд, ажлаа явуулахын тулд бас энэ төрийн эрх барих дээд байгууллагадаа хүндэтгэлтэй ханд. Би 3 минутдаа үгээ хэлсэн шүү.

Ажлын хэсгээс орж ирсэн Засгийн газарт чиглэл өгөх тухай тогтоолын төсөлд бас хуулийн маргаан байгаа учраас хэдүүлээ Тамгын газраас дүгнэлт гаргуулаад, тэгээд үргэлжлүүлээд дараа нь хэлэлцье.

Ингээд үргэлжлүүлж хэлэлцэхээр тогтлоо. /алх цохив/

Хоёр.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх тухай асуудал

Хоёр дахь асуудал. Хоёр дахь асуудалдаа орьё.

Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшүүлэх тухай асуудлыг хэлэлцэж эхэлье.

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүн нэг хүнийг Төсвийн байнгын хороонд нэр дэвшүүлэхээр заасны дагуу Байнгын хорооны 2025 оны 05 сарын 21-ний өдрийн хуралдаанаар “Нэр дэвшигчийг бүртгэх тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг бид баталж,

сонгон шалгаруулалтын зарыг нийтэд хүргүүлсэн бөгөөд 2025 оны 06 сарын 04-ний өдрийн 17 цаг 30 минутаар тасалбар болгосон.

Төсвийн байнгын хорооны 213 тоот өрөөнд Төрийн ордны шуудан бичгээр цахимын материалыг хүлээж авсан.

5 материал ирсэн. 5 материалаас 3 хүний материал иж бүрдэл хангасан Ч.Дөл-Эрдэнэ, С.Энхбаяр, Ө.Гэрэлт-Од.

М.Ариунболд, Ц.Мөнхсайхан нар Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хууль тийн 11.6-д заасан тухайн чиглэлээр мэргэшсэн, тухайн албан тушаалыг хашихад шаардлагатай түвшний мэдлэг, чадвар, туршлага, ёс зүйтэй гэдгийг нотлон харуулсан 10-аас доошгүй тодорхой үйл ажиллагааны талаарх баримт ирүүлэх ёстой гэсэн байхгүй юу.

Үүнийг ирүүлээгүй байгаа учраас энэ хоёр бол баримтын иж бүрдэл хангаагүй байна.

Ингээд нэр дэвшихээр хүсэлтээ ирүүлсэн 5 хүний бичиг баримтын бүрдэл хангасан 3 хүний товч танилцуулгыг би Та бүхэнд танилцуулаад, тэгээд санал хураалт явуулна.

Цагаан толгойн үсгийн дарааллын дагуу танилцуул гэсэн юм байна шүү дээ. Болох юм уу? Аан. Тэгвэл шууд хураачих уу?

Горимын санал аа? Горимын санал чинь нөгөө хурлын тов, дэс дарааллын дагуу л гарах ёстой юм билээ шүү дээ.

Байж бай. Хөөш. Энэ юуг нь харъя. Ямар горимын санал гаргах юм. Тэгэхгүй бол би бас зөрчиж болохгүй шүү дээ. Миний ямар шаардлага байдаг юм.

Үгүй ээ, энэ би хуульд заасан шаардлагуудыг л ярьж байна шүү дээ. Миний шаардлага гэж юу байдаг юм. Юун балай юм яриад байгаа юм чи одоо. Юу нь үнэн байгаа юм. Тэгээд гараач дээ тэгээд. Солиороод байх юм.

Х.Булгантуяагийн микрофоныг.

Х.Булгантуяа: Байнгын хорооны гишүүддээ энэ хэлэлцэх асуудлыг хойшлуулах горимын саналыг гаргаж байна.

Сая үүнтэй холбоотой материалыг дөнгөж сая нэг ийм боть ном шиг материал авлаа. Тэгээд ер нь Төсвийн байнгын хорооны гишүүдийн хувьд материалтай танилцаж байж дахиж энэ асуудлыг хэлэлцэх нь зүйтэй гэж үзэж байна.

Тэгээд Байнгын хорооны гишүүддээ дэмжихийг хүсэж байна.

Ц.Даваасүрэн: Материалыг өчигдөр тараасан байгаа шүү. Энэ 3 хүний, 4, 5 хүний материалыг уншихад ерөөсөө нэг их тийм цаг зав аваад шаардаад байх юм байхгүй шүү дээ.

Ингээд яах вэ, нэгэнт хурлын дарааллын талаар горимын санал гаргах эрхтэй учраас горимын санал нь хойшлуулъя гэж байгаа юм байна. Тийм үү?

Ер нь материал авах цаг хугацаа 17 цаг 30 минут, 06 сарын 04-ний өдрөөр хаагдсан байгаа гэдгийг хэлье.

Ингээд Х.Булгантуяа гишүүний гаргасан горимын саналын дагуу хуралдааныг хойшлуулъя гэдэг саналаар санал хураалт явуулъя. /алх цохив/

19-өөс 4 гишүүн дэмжиж, 21.1 хувиар санал дэмжигдсэнгүй.

Ингээд санал хураалтдаа орёё.

Цагаан толгойн үсгийн дарааллаар. Ийм байна шүү. Ингэе. Нэр дэвшигчийг дэмжсэн тохиолдолд дараагийн хүний саналыг хураахгүй гэж байна шүү.

Эхний нэр дэвшигч олонхын санал авах юм бол байна шүү дээ. Авахгүй бол тэгээд дараагийнх явах юм байна. Тэгээд цагаан толгойн үсгийн дарааллын дагуу хураах юм байна шүү. Нэг нь л сонгогдоно шүү дээ. Тэгэхдээ олонхын санал авсан нь.

Цагаан толгойн үсгийн дарааллын дагуу. Тэгвэл тэгье.

Өвгөнхүү овогтой Гэрэлт-Од гэж байна. 1970 онд Дундговь аймгийн Мандалговь хотод төрсөн гэж байна.

Ингээд Монгол Улсын Их Сургуулийн банкны эдийн засагч мэргэжлээр бакалавр, Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуулийн бизнесийн удирдлагын магистр, Монгол Улсын Их Сургууль Бизнесийн удирдлагын докторын зэрэг хамгаалсан.

1993-1996 онд Ардын банканд нягтлан бодогч, салбарын захирал,
1996, 2000 онд Хадгаламж банканд төвийн захирал,
2009 оноос Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн сургуульд багш,
дэд профессор,

2009-2013, 2019, 2024 онуудад Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн сургуулийн Бизнес консалтинг төвийн захирал,

2024 оноос Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн сургуулийн Санхүүгийн танхимын эрхлэгч,

2017 оноос “Нийслэл Аудит” ХХК шинжээч,
2023 оноос “Багануур” ХХК ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллаж байна.

Нинж овогтой Дөл-Эрдэнэ 1978 онд Орхон аймгийн Баян-Өндөр суманд төрсөн.

Монгол Улсын Их Сургуулийн Эдийн засгийн дээд сургуулийг санхүүч, мэдээлэл зүйч, эдийн засагч мэргэжлээр бакалавр, Санхүү, эдийн засгийн дээд сургуулийн Бизнесийн удирдлагын магистр, Тайвань Улсын Хятадын Соёлын их сургуулийн Олон улсын бизнесийн удирдлагын докторын хөтөлбөр, Санхүү, эдийн засгийн их сургуулийн Бизнесийн удирдлагын докторант.

1999-2001 онд Монгол Улсын Их Сургуулийн лицей сургуульд Мэдээлэл зүйн багш,

2001-2002 онд Тээвэр, хөгжлийн банканд зээлийн эдийн засагч,
2002-2011 онд Чингис хаан банканд газрын захирал, ахлах эдийн засагч,
2011-2012 онд “Эм Си Эс Холдинг” ХХК-д хөрөнгө зохицуулалтын менежер,

2014-2023 онд Монголын хөрөнгийн бирж төрийн өмчит хувьцаат компанид Захиргаа, санхүүгийн газрын дарга,

2023-2004 оны 9 сар хүртэл “Сайн интернэйшнл” ХХК-д Лизингийн хариуцсан дэд захирал,

2023 оноос “Томьёо нэгдэл” ХХК-ийн үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирлаар ажиллаж байна.

Лхагвасүрэн овогтой Энхбаяр 1987 онд Төв аймгийн Зуунмод хотод төрсөн.

Тагнуулын ерөнхий газрын дээд сургуулийн эрх зүйн гадаад хэлний мэдлэгтэй. Аюулгүй байдлын бакалавр.

Америкийн Нэгдсэн Улсын Юта мужийн их сургуулийн улс төр судлал, Монгол Улсын Их Сургуулийн Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийг олон улсын эрх зүйн магистр, Үндэсний тагнуулын академид Аюулгүй байдлын магистрын зэрэг хамгаалсан.

2009-2012 онд Монгол Улсаас Америкийн Нэгдсэн Улсад суугаа Элчин сайдын яамны Консулын туслах,

2012-2013 онд Монгол Улсаас Австралийн Холбооны Улсад суугаа Элчин сайдын яамны Консулын туслах,

2013-2017 онд Терроризмтай тэмцэх зөвлөлийн ажилтан,
2018-2019 Тагнуулын ерөнхий газрын Мөнгө угаах гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн дарга,

2019-2020 онд Терроризмтой тэмцэх зөвлөлийн нарийн бичгийн дарга,
2020-2022 онд Тагнуулын ерөнхий газрын Мөнгө угаах, терроризмын санхүүжилттэй тэмцэх хэлтсийн дарга,

2022-2023 онд Тагнуулын ерөнхий газрын орон нутаг дахь газрын дарга
2023 оноос НҮБ-ын дүрвэгсдийн асуудал эрхэлсэн Дээд комиссын газрын Монгол дахь төлөөлөл, ахлах мэргэжлээр ажиллаж байна.

Ийм 3 хүнийг танилцууллаа.

Ингээд цагаан толгойн үсгийн дарааллын дагуу санал хураалт явуулъя.

Ингэж байна. Улаанбаатар хотод төрсөн, Дундговь аймагт төрсөн, Орхон аймагт төрсөн юм байна. Үсгийн дарааллын дагуу ч Ө.Гэрэлт-Одыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Бэлтгэл хангая гэдэг нөгөө шинэ горимоор явах юм байна.

Гишүүд ээ, санал хураалт бэлтгэл хангагдсан уу.

Ингээд санал хураалтыг цагаан толгойн үсгийн дарааллын дагуу Ө.Гэрэлт-Одыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнээр нэр дэвшүүлэхийг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

19-өөс 11 гишүүн, 57.9 хувиар дэмжигдсэн байна.

Ингээд олонхын санал авсан учраас Ө.Гэрэлт-Одыг нэр дэвшүүлэх асуудлыг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 111.6-д заасны дагуу хэлэлцэж дууслаа.

Нэр дэвшигч Ө.Гэрэлт-Од нь 11 гишүүн буюу 57.9 хувийн санал авсан тул нэр дэвшүүлэхийг дэмжлээ. /алх цохив/

3.Мэндсайхан гишүүнийг дэмжсэнээр авах юм байна. Протоколд.

**Гурав.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд
нэр дэвшүүлэх тухай асуудал**

Гурав дахь асуудалд оръё.

“Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцэж эхэлье.

Тогтоолын төслийг би Та бүхэнд танилцуулъя.

Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох тухай, сонсгол даргалагчийг сонгох тухай.

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3.13 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1 дэх заалт, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, Нийтийн сонсголын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэг, 130 дугаар зүйлийн 130.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн Төсвийн байнгын хорооноос ТОГТООХ нь:

1.Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны бус гишүүнд нэр дэвшигч нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчдийн сонсголыг 2025 оны 06 сарын 25-ны өдөр зохион байгуулахаар тогтоосугай.

2.Нэр дэвшигчийн сонсгол даргалагчаар Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямыг томилсугай.

3.Нэр дэвшигчийн сонсголын талаар нийтэд мэдээлэх, сонсголын бэлтгэл хангах ажлыг холбогдох хууль журмын дагуу зохион байгуулахыг Монгол Улсын Их Хурлын Төсвийн байнгын хороо Ц.Даваасүрэнд даалгасугай.

Ийм тогтоол байна. Тогтоолын төсөлтэй холбогдуулан асуух асуулттай гишүүн байна уу? Алга байна. Үг хэлэх гишүүн байна уу? Алга байна.

“Нэр дэвшигчийн сонсголын тов тогтоох тухай, сонсгол даргалагчийг сонгох тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг баталъя гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. /алх цохив/

19 гишүүн оролцож, 11 гишүүн дэмжиж, 57.9 хувиар тогтоолын төсөл дэмжигдлээ.

Тогтоолын төслийг хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооны хуралдаан өнөөдөр үүгээр дуусаж байна. Баярлалаа гишүүд ээ. /алх цохив/

Хуралдаан 2 цаг 12 минут үргэлжилж, 12 цаг 40 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД